

# MONGOLIAN ECONOMY

2014 ОНЫ 6 САР. №11 (069)

ЭДИЙН ЗАСАГ  
ҮНЭ ЦЭНЭТЭЙ ҮНЭТ ЦААС

ЭДИЙН ЗАСАГ  
БҮТЭЭГДЭХҮҮН БА ТЕХНОЛОГИЙН  
“УРАЛДААН”

ЭДИЙН ЗАСАГ  
НОГООН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ  
БАНКУУДЫН НЭГДЭЛ


# 90

ӨНГӨРСӨН  
ОДОО  
ИРЭЭДҮЙ  
МОНГОЛЫН БАНК

МОНГОЛЫН БАНК



МОНГОЛБАНК





**ХААН БАНК**



**RETAIL BANKER  
INTERNATIONAL**  
Asia Trailblazer Awards 2014  
Product Excellence in Payment Innovation

**EUROMONEY**  
2006  
2007  
2008  
2009  
2010  
2012


**The Banker**  
2004  
2005  
2006  
2007  
2008  
2010

**GLOBAL VANGUARD**  
2003  
2005  
2006  
2007  
2008  
2009  
2011

*Банкны тогтолцоо урсч бэхэжсэний турхт  
90 жилийн ойн баярын мэнд хүрлэе!*

## **ТАНЫ ИТГЭЛ**

БИДНИЙ АМЖИЛТЫН ҮНДЭС



Улс орон даяар байрлалтай 530 салбар нэгжээрээ дамжуулан ХААН Банк Монгол улсын өнцөг булан бүрт хүрч үйлчилдэг билээ. Компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэгч ХААН Банк олон улсын стандартад нийцсэн банк санхүүгийн иж бүрэн үйлчилгээг нийт харилцагчиддаа үзүүлж байна.



Монгол Улсад банкны тогтолцоо үүсч бэхэжсэний түүхт 90-н жилийн ойн баярын мэнд гэрвүүлэе!



## МОНГОЛД АНХ УДАА



Монголд анх удаа  
Олон улсын  
төлбөрийн картын  
системийг  
нэвтрүүлэв



Монголд анх удаа  
Интернэт банкны  
үйлчилгээг  
нэвтрүүлэв

Монголд анх удаа  
Ухаалаг утсанд зориулсан  
банкны аппликейшн болох  
Смарт банк үйлчилгээг  
нэвтрүүлэв



Монголд анх удаа  
Вестерн Юнион үйлчилгээг нэвтрүүлэв



Монголд анх удаа  
Өөртөө үйлчлэх банкны үйлчилгээг  
нэвтрүүлэв



Монголд анх удаа  
Аюулгүй байдлын №1  
стандарт EMV чип  
картыг нэвтрүүлэв

ЧИНГИС  
ХААН  
БАНК



ЧИНГИС ХААН БАНК

*Ирээдүйг хөрөнгө оруулал*

Банкны  
үйлчилгээнүүд

байгууллагын банк болон иргэдийн банкны үйлчилгээ, хөрөнгө оруулалтын банк,  
төслийн санхүүжилт, санхүүгийн зөвлөгөө, гадаад худалдааны санхүүжилт


Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө - 15, Нью Сенчюри Плаза. Утас: 976-11-318367, Факс: 976-11-318373  
И-мэйл: [bank@ckbank.mn](mailto:bank@ckbank.mn) Вэб: [www.ckbank.mn](http://www.ckbank.mn)



1



2



1

Соронзон туузтай карт

2

ЧИП карт

# УДАХГҮЙ ТАНЫ УТСАНД

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

Монголын сэтгүүлдийн эвлэлийн  
“2013 оны Шилдэг сэтгүүл”

**ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:**

Д.Бэхбаяр / 9999-4248

**ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:**

И.Отгонжаргал / 8800-6228

**АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:**

Теренс Эдвардс

**ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТЭН:**

Лиззи Хүү

**ОРЧУУЛАГЧ:**

Р.Гантулга

**ВЭБ РЕДАКТОР:**

Б.Энхцэцэг

**СЭТГҮҮЛЧИД:**

Б.Баяртогтох

Э.Зоригт

Б.Үүрийнтуяа

С.Батзаяа

**ДИЗАЙНЕР:**

Ш.Оюундарь

**ВЭБ МАСТЕР:**

Н.Гал

**МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:**

Д.Барянжав / 9409-2904

**БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:**

М.Хишигтогтох / 9409-2906

**“ECONOMY” ТВ СТУДИ**

**СЭТГҮҮЛЧ:**

Ц.Соёлмаа

**ЗУРАГЛААЧ:**

Ш.Гантуул

**КОМПЬЮТЕР ГРАФИКЧ:**

Т.Баярсайхан

**ХАЯГ:**

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AB center. 503 тоот

15160 Улаанбаатар,

Төв шуудан, ш/ х-2762

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

[info@mongolianeconomy.mn](mailto:info@mongolianeconomy.mn)

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

[www.ubprint.mn](http://www.ubprint.mn)



MONGOLIAN ECONOMY  
ОНЛАЙН СЭТГҮҮЛ  
[mongolianeconomy.imedia.mn](http://mongolianeconomy.imedia.mn)

## АГУУЛГА

### ЭДИЙН ЗАСАГ

- 10 Түүхэн хөгжил
- 12 Үнэ цэнэтэй үнэт цаас
- 14 90 жилийн түүх ололт амжилт, бэрхшээлтэй нүүр тулсан цаг хугацаа



- 22 Тоон мэдээ
- 24 Даатгагдсан ирээдүйг дагах эрсдэл бий юу
- 26 Зураг түүх өгүүлнэ
- 28 Банкны системийн хөгжлийн явц амар хялбар байгаагүй
- 30 Хямралыг давж, өсөлт өөд мацсан он жилүүд
- 34 Мөнгөн тэмдэгтийн түүх
- 36 Бүтээгдэхүүн ба технологийн “уралдаан”
- 38 Ногоон хөгжлийн төлөөх банкуудын нэгдэл
- 41 Эрсдэл

## “ECONOMY” ТВ СТУДИ

“ЭРЧИМ ХҮЧ-ХӨГЖЛИЙН ГЭРЧ” нэвтрүүлэг

Нэвтрүүлэх суваг: NTV телевиз

Нэвтрүүлэх цаг: 2014.06.03-ны 18.50

Олон улсад эрчим хүчний салбарыг улсын хөгжлөөс 20 жилээр түрүүлж алхах ёстой гэж үздэг. Тэгвэл Монголд ямар байна вэ. Бид тэр хөгжлийг авчрахын тулд юу хийх ёстой бол.

### “MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БЯМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД “Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

С.БЭХБАТ ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН МIН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮХ СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА “Пийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

#### Борлуулах цэгүүд:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетийн бүх салбар

“Макс” супермаркетийн бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр дэх салбар

“Max mall” салбарууд



facebook.com/Mongolian.  
Economy



twitter.com/EconomyMon-  
golia



youtube.com/user/Mongo-  
lianEconomy

## ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



**Б**анкны салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойн баярыг “Mongolian Economy” сэтгүүл хуваалцаж байгаадаа баяртай байна. Зах зээлд шилжсэн сүүлийн 20 гаруй жилд хурдацтай хөгжиж, Монголын эдийн засаг, бизнест өөрийн жинтэй хувь нэмэр оруулж яваа салбаруудын тэргүүн эгнээнд банк бичигдэх нь түүхэн үнэн.

Шинэ мянганы эхэн үе хүртэл монголчууд банкны үйлчилгээний мөн чанар, үр дүнг нь төдийлэн сайн мэдэрч, түүнтэй нөхөрлөдөггүй байлаа. Харин одоо бол өлгийтэй хүүхдээс авахуулаад өндөр настан буурлууд ч банкны үйлчилгээг санасан цагтаа авдаг болсон. Монгол хүн ертөнцийн хаана ч явсан олон улсын карт эзэмшиж, мөнгөн гүйлгээг төвөггүйхэн хийх боломжтой.

Монгол Улсад өнөөдөр арилжааны 13 банк бий. Хот, орон нутгийн иргэд, хонины бэлчээрт буй малчдын хэтэвчинд ч дээрх арилжааны банкуудын бараг талынх нь төрөл бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний карт, хадгаламжийн дэвтэр хадгалаастай яваа. Монгол хүн бүр банкинд данстай учраас тэр. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд банкны нийт 1500 орчим салбар байгаагийн 1000 гаруй нь хөдөө орон нутагт байдаг. Нийт 20 гаруй их наяд төгрөг банкуудад эргэлдэж байна. Өргөн уудам нутагт, тархай суурьшилтай монголчуудад банкны үйлчилгээг ийм хүртээмжтэй хүргэж чадсаныг үнэхээр гайхамшиг гэхээс яалтай. Энэ тухай манай сэтгүүлийн “Редакцийн уулзалт”-д оролцсон томоохон банкны захирлууд нэгийг санаж, хоёрыг бодохоор зүйлүүд ярьсаныг Та сонирхоорой. Тухайлбал, Монголын банкны холбооны тэргүүн М.Болд “Том эдийн засагтай зарим улс ч банкны үйлчилгээг хүн амдаа бүрэн төгс хүргэж чадаагүй байгаа. Тэд бидний тоонд хүрэх гэж мөрөөдөж байна” хэмээн онцолсон. Тэгэхээр манай банкны салбарын хөгжил хэр хурдацтай явааг эндээс харж болно.

Түүнчлэн төлбөр тооцооны тогтолцоог орчин үеийн технологи-шийдлээр иж бүрэн шинэчлэх ажил амаргүй байсныг Монголбанкны ерөнхийлөгч асан Л.Пүрэвдорж түүхэн ойд зориулсан дурсамж өгүүлэлдээ бичсэн байсан. Мөн Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд асан Д.Моломжамц гуайн дурсамж өгүүллээс Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсч бэхжих явцад хэдэнтээ унаж, боссон тухай олон сонирхолтой түүхийг залуу үе мэдэж болохоор байна. Төлбөр тооцооны тогтолцоог улам боловсронгуй болгох ажил одоо ч үргэлжилсээр.

Мөн моргейж Монголд юу авчирсан, иргэдийн хадгаламжийн даатгалын тогтолцоо, банкны ногоон бодлого, тогтвортой санхүүжилтийн талаар ч манай сэтгүүлчид банкны тухай шинэхэн дугаартаа хөндөн бичлээ.

Эцэст нь хэлэхэд манай, улсад банкны системийн хөгжил нэлээд өндөр түвшинд очсон ч гэлээ нөгөө талдаа олон улсын түвшинд авч үзэхэд, банкууд маань жижиг байна. Эдийн засаг өсөхийн хэрээр банкны салбарт хөрөнгөө зузаатгах, хууль эрх зүйн зохицуулалт гээд тулгарч буй асуудал багагүй бий. Өрсөлдөөн гадагшаа тэлж буй учраас хөгжил улам хүчээ авна гэдэгт итгэнэм.

**Орлогч эрхлэгч И.Отгонжаргал**

## МЭНДЧИЛГЭЭ




Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсч бэхэжсэний 90 жилийн ойг тохиолдуулан банк, санхүүгийн салбарыг хөгжүүлэх үйлсэд өөрийн мэдлэг оюун, хөдөлмөр зүтгэл, ур чадвараа дайчилж, үр бүтээлтэй ажилласан ахмад ажилтан, бидэнтэй нэгэн зорилгын төлөө хамтран ажиллаж байгаа мэргэжил нэгт Та бүхэндээ Монголбанкны хамт олны өмнөөс болон хувиасаа түүхт ойн баярын мэндийг дэвшүүлье.

Эртний Хүннү гүрэн, Монголын эзэнт гүрэн, Их Юань гүрний үед зоос мөнгө, таваар-мөнгөний харилцааг ухаалгаар ашиглаж, “Мөнгөний хэрэг эрхлэх хэлтэс” хэмээх мөнгөн гүйлгээ эрхэлсэн байгууллага байгуулан, дэлхий дахинд анхны цаасан дэвсгэртийг 1260 онд гүйлгээнд оруулж байсан бидний баялаг түүх зуун дамжин үргэлжилсээр 1924 оны зургаадугаар сарын 2-ны өдөр Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк(Монголбанк)-ийг байгуулсан нь орчин цагийн банкны тогтолцоо үүсч бэхэжсэний эхлэл болсон билээ. Өдгөө Монгол Улсад 13 банк, 1400 гаруй салбар, нэгжтэйгээр банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Банкны салбарын нийт активын хэмжээ 20.7 их наяд төгрөг, хадгаламж эзэмшигчдийн тоо 2.5 сая, зээлдэгчдийн тоо 694 мянга болж өсчээ. Монголбанк Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн урт хугацааны өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж ирсэн билээ. Энэ хүрээнд санхүүгийн салбарыг бэхжүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх, иргэдийн бодит орлогыг хамгаалах, нийгмийн дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын шинэчлэлийг хийж, үр дүнд хүрч байгааг тэмдэглэхэд таатай байна.

Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсч бэхэжсэний түүхт 90 жилийн ойн мэндийг дэвшүүлж, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЗОЛЖАРГАЛ



## БАНК-90

## ТҮҮХЭН ХӨГЖИЛ

## Б.БАЯРТОГТОХ

Монгол Улсын хэмжээнд 60 гаруй мянган аж ахуйн нэгж бий. Түүнээс 13 байгууллага арилжааны банкны тусгай зөвшөөрөлтэй. Тэдний тав нь гадаадын хөрөнгө оруулалттай. Энэ нь банкны системийн 38 хувийг эзэлж байна. Өнгөрсөн хугацаанд /1994-1999 / чанаргүй зээлийн түвшин 17 орчим хувьд дөхөж, таван зээл тутмын нэг нь “эрсдэж” байсан үе банкны системд байсан. Тэгвэл сүүлийн жилүүдэд чанаргүй зээлийн хэмжээ эрс буурч, муу зээлийн түүх давтагдах нь цөөрсөн. Санхүүгийн салбарын толгойд яваа банкны хөгжлийн түүх тийм ч дардан байгаагүй. Гэхдээ Монголын эдийн засгийг банк, түүний үүрэг оролцоогүйгээр төсөөлөх боломжгүй.

Сүүлийн 22 жилийн хугацаанд манай улсад 31 банк байгуулагдсан байдаг. Үүнээс 15 нь дампуурч, гурван банк нэгдэж, өнөөдрийн байдлаар 13 банк үйл ажиллагаа явуулж буй. 2005 оноос хойш шинээр арилжааны банк байгуулах тусгай зөвшөөрөл олгогдоогүй бөгөөд цаг хугацааны явцад банкны салбар томорч хөгжсөөр. Арилжааны банкны дүрмийн сан 16 тэрбум төгрөгт хүрч, анх 50 сая төгрөгөөр босго тогтоож байсан үе ард хоцорлоо.

1990 оны эхээр хоёр шатлалт банкны тогтолцоонд шилжсэнээс хойших алдаа, оноо бидний нүдэн дээр өрнөх болсон. Түүний өмнөх түүх төдийлэн дурсагдаад байдаггүй. Гэтэл түүхэн хөгжлийн замнал нь 90 жилээр хэмжигдэх тус салбар Ардын хувьсгал ялсан үеэс улбаатай. Өөрөөр хэлбэл, XX зууны эхэн үеэс Монголд банкны салбар хөгжих суурь нь тавигджээ. Нэг талаар Монголын банкны салбарын 90 жил бүхэлдээ улсын санхүүгийн системийн хөгжлийн түүх гэж хэлж



болохоор. Тиймээс хүндэтгэх өндөр их ой энэ онд тохиож байна.

Худалдаа ба аж үйлдвэрийн банк

Зах зээлд хязгааргүй ноёрхож байсан гадаадын худалдаачид, мөнгө хүүлэгчдийг шахах үүднээс үндэсний банк, мөнгө зээлийн системийг үүсгэн байгуулах, улс төр, эдийн засгийн амьдралыг бүхэлд нь өөрчлөн төвхнүүлэхээр Ардын Засгийн газраас хэд хэдэн чухал ажлыг санаачилжээ. Эдгээр ажлын нэг нь 1924 оны зургадугаар сарын 2-ны өдөр биелэлээ олж, Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн хөрөнгөөр Худалдаа ба аж үйлдвэрийн банк нэг салбартайгаар нээгджээ. Энэ нь өнөөдрийн Монголбанк. Ингэснээр үндэсний зээлийн тогтолцоог бүрдүүлэх анхны практик алхам хийгдэж, уг тогтолцооны үндэс суурь тавигджээ.

Хувь нийлүүлсэн банкны анхны жилүүдийн үйл ажиллагаа хөдөө аж ахуй, үйлдвэрийн хөгжилд түлхэц өгөх, худалдааг өргөжүүлэн, улс орны мөнгөний гүйлгээг эмх замбараатай болгон зохицуулахад чиглэж байжээ. Монголбанк нь үндсэндээ хувийн хэвшлийн ноёрхож байсан барааны зах зээлийн эрэлт, хэрэгцээний голлох

барааны үнийн хөдөлгөөнд идэвхтэй нөлөөлж, зээлийн гүйлгээг өргөжүүлэх хөрөнгө дайчлан хуримтлуулах зорилттой.

Тухайн үед банк анх үйл ажиллагаа явуулж эхлэхдээ 260 мянган янчааны хөрөнгөтэй, 22 орон тоотой байсан бөгөөд үүний дотор зөвлөлтийн 18 мэргэжилтэн байжээ. Дөрвөн ажилтны хоёр нь буюу Цэдэн-Иш, Бат-Очир нь бичиг үсэг мэддэг, үндэсний сэхээтний төлөөлөл төдийгүй Монголбанкны ерөнхий хорооны гишүүнээр ажиллаж байсан хэмээн түүхэнд тэмдэглэсэн байна.

Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банкны анхны салбар Алтанбулагт байсан бөгөөд салбарын даргаар нь Ф.С.Власов, няраваар И.В.Маркевич ажиллаж байжээ. Хоёр орны хувь нийлүүлсэн банкныг байгуулахдаа Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк, Монголбанк гэсэн хоёр нэрийг хэрэглэдэг байсан ч ихэвчлэн Монголбанк гэж нэрлэн хэвшжээ.

## Төгрөгийн түүх

Та бидний өдөр тутмын санхүүгийн гүйлгээг зохицуулж байдаг төлбөрийн хэрэгсэл бол төгрөг. Үндэсний тусгаар тогтнолыг илэрхийлэх мөнгөн тэмдэгт. БНМАУ-ын Засгийн газар 1925 оны хоёрдугаар сарын 22-нд мөнгөний шинэчлэлт явуулах тухай тогтоол гаргаж, Монголын үндэсний мөнгөний нэгжийг “төгрөг” хэмээн нэрлэсэн түүхтэй. Тухайн үеийн Монголбанкинд төгрөгийн 25 хувь нь үнэт металл гадаадын тогтвортой валютаар, 75 хувь нь түргэн борлогдох бараагаар батлагдсан мөнгийг гүйлгээнд гаргах эрх олгожээ. Ингэснээр мөн оны 12 дугаар сарын 9-нд 200 144 төгрөгийн мөнгөн тэмдэгт, цагаан зоосыг анх гүйлгээнд гаргасан нь Монгол оронд ▶

▶ мөнгөний гүйлгээ шинэ түвшинд хөгжих бодитой эхлэл болж өгчээ. Монголбанк энэ үеэс гүйлгээнд мөнгө гаргах эрх бүхий үүрэг гүйцэтгэх болжээ.

Төгрөг анх гүйлгээнд гарахдаа 0.88 хятад янчаатай тэнцэж байсан бол 11 сар хүрэхгүй хугацааны дараа 0.95 янчаатай, бүтэн хагас шахам жилийн дараа буюу 1927 оны дөрөвдүгээр сарын 16-ны өдөрөөс эхлэн төгрөг янчаан хоёрын ханш тэнцжээ. Энэ хугацаанд төгрөг хүн амын итгэлийг олсон тул янчааныг гүйлгээнээс шахан гаргах бодлого барьж банкинд орж ирсэн янчаан болон бусад гадаад валютыг гүйлгээнд эргүүлэн гаргахгүй болжээ. Үүнийг БНМАУ-ын мөнгөний шинэчлэлийн I үе шат буюу Монголын зах зээлийн төлөө янчаантай хийсэн өрсөлдөөний үе гэдэг. Хоёр дахь үе шатанд мөнгөн дэвсгэрт төгрөг мөнгөний гүйлгээнд баттай байр суурь эзлэх болж, алтан баталгаанд суурилснаар тогтвортой хатуу валютуудын тоонд орж эхэлсэн. Үүнийг шинэчлэлийн хоёрдахь үе шат гэж үздэг.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1954 оны зургаадугаар сарын 2-ны өдрийн 120 дугаар тогтоолоор Монголбанкийг БНМАУ-ын Улсын банк болгон өөрчилж, түүний дүрэм, зохион байгуулалтыг баталсан билээ. Улсын банк нь Монгол Улсад ажиллаж байсан цорын ганц банк тул үйлдвэр, аж ахуйн газруудад зээл болон бэлэн мөнгө тавьж олгох, гүйлгээнд шинээр мөнгөн тэмдэгт гаргах, гүйлгээнээс мөнгө татах зэрэг ажлыг гүйцэтгэж байжээ.

## Тогтолцооны хувьсал

Банкны салбарт шинэ салхи сэвэлзэж эхэллээ. Энэ үе бол 1980-аад оны сүүлчээс эхтэй. Нэг шатлалт, банкны монополь системийн хэт төвлөрсөн, удирдлагатай уялдсан олон шат дамжлага нь харилцагч байгууллага, иргэдийг чирэгдүүлж, хүнд суртал тоймгүй байгаа нь шүүмжлэгдэх болжээ. Түүнчлэн тэр үеийн нам, засгийн удирдлагаас банкны ажилд гүнзгий хутгалдан оролцох, хаана хөрөнгө мөнгө дутагдаж, шаардагдана түүнд их хэмжээний зээлийг хөрөнгийн

эх үүсвэр баталгааг харгалзахгүйгээр олгох чиглэх өгөх нь олширсон. Зарим салбарт хүүгүй эсвэл хөнгөлөлттэй хүүтэй зээл олгохыг үүрэгдэх болж. Мөн авсан зээлээ төлж чадахгүй нэгдэл, байгууллагын зээлийн өрийг хүчингүй болгох шийдвэрийг удаа дараа гаргах болсон гэдэг. Үүнээс үүдэн банкнаас аль болох их зээл авч, түүнээ хөнгөлүүлэх, хүчингүй болгох эрмэлзлэл ихэсч, бүхнийг зээлээр хөдөлгөх бэлэнчлэх сэтгэлгээ бүрэлдэн тогтоход хүрчээ. Нэг банкны монопольт систем ингэж шүүмжлэгдэх болж, зах зээл, цаг үеийн зүй ёсны шаардлага, нийгмийн “захиалга”-аар шинэ банк байгуулах санал удаа дараа гарч, хоёр шатлалт банкны тогтолцоонд эргэлт буцалтгүй улсаараа шилжжээ.

Тухайн үед Газар тариалангийн банк, Үйлдвэр, худалдааны банк, Монголын Улаан Загалмайн банк, Аж үйлдвэрийн банк байгуулах хүсэлт Улсын банкны ерөнхий хорооны хурлаар орж байсныг Монголбанкны түүхийн талаарх өгүүлэлд дурджээ. Энэ нь Монголд арилжааны банк байгуулах анхны гараа, шинэ банк байгуулах асуудлыг Төвбанкнаас шийдвэрлэх анхны сургууль болж өгсөн гэдэг. Ингэснээр 1990 онд Монгол даатгал банк, 1991 онд Худалдаа хөгжлийн банк, Хөрөнгө

оруулалт, технологи шинэчлэлийн банк байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлжээ.

Өөрөөр хэлбэл, Монголд банкны тухай хууль гарахаас өмнө, олон банкны тогтолцоот системд баримтлах чиглэл тогтоогүй байхад анхны арилжааны банкууд үүсэн байгуулагдсан аж. Үүний дараагаар Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм, 1991 онд Банкны тухай хууль батлагдсанаар хоёр шатлалт банкны тогтолцооны хөрс суурь тавигджээ. Энэ үед арилжааны банкууд өөрсдийн ажиллагсдын дотроос төлөөлөгч сонгож, Монголын арилжааны банкуудын холбооны дүрмийг баталж байжээ.

Сүүлийн 20 жилд Монгол Улсын санхүүгийн захыг үндсэндээ банкны систем тодорхойлж буй. Монгол орон даяар зах зээлийн тогтолцоонд орох шилжилтийн эхэнд банкны систем тэр аяараа өөрчлөгдөж, шинэ тогтолцоонд шилжсэн нь бусад салбарын өөрчлөлтөд ч түлхэц болсон билээ. Монгол Улсад цоо шинэ систем буюу Монголбанк, хувь нийлүүлэгчдийн хувь хөрөнгөөс бүрдсэн арилжааны банк гэсэн хоёр шатлалт банкны систем бүрэлдсэн тогтсон нь энэ.

## Он цагийн хэлхээс

- 1227 - Манай улс дэлхийд анх удаа цаасан мөнгө гаргасан
- 1924 - Худалдаа Аж Үйлдвэрийн Банк байгуулагдсан
- 1925 - Үндэсний валютыг төгрөгөөр тогтоосон
- 1926 - Цагаан мөнгөн зоос анх гүйлгээнд гаргасан
- 1931 - Урт хугацаатай зээл өгч эхэлсэн
- 1940 - Улсын төсөв Монголбанкаар дамжих болсон
- 1946 - Зээлийн барьцаа эхэлсэн
- 1954 - Монголбанк Монгол Улсын Засгийн газрын мэдэлд бүрэн шилжсэн
- 1963 - Монгол Улс олон талт тооцооны системд шилжсэн
- 1991 - 2 шатлалт банкны тогтолцоог нэвтрүүлсэн
- 1992 - Клирингийн тооцоо эхэлсэн
- 1993 - Монголбанк хяналт шалгалтын ерөнхий чиглэлийг баталсан
- 1994 - Нягтлан бодох бүртгэлийн шинэ тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн ■

## ИПОТЕК

## ҮНЭ ЦЭНЭТЭЙ ҮНЭТ ЦААС

## Б.БАЯРТОГТОХ

Нийслэлийн оршин суугчдын 60 гаруй хувь нь гэр хороололд амьдарч байна. Үүнийг бууруулахаар хийж буй томоохон ажлын нэг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” юм. Монголбанкнаас нийгмийн дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэхийг зорилгоо болгож буй. Ингэснээр эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг мөнгөжүүлсэн. Хөтөлбөр хэрэгжээд жилийн ойндоо хүрэх гэж байна. Энэ хугацаанд банкууд нийт 37438 иргэнд нэг их наяд төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгож, 520.5 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлжээ. Монголбанк орон сууцны ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэх болон шинээр зээл олгоход зориулж 1.5 их наяд төгрөгийг арилжааны банкуудад жилийн өмнө байршуулсан. Үүний 51.3 хувь нь 2013 оны эцэст шинээр орон сууцны ипотекийн зээл болж гарсан байна.

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бий болсноор Монгол Улс хэрэглээний эдийн засгаас хуримтлалтай эдийн засагт шилжих, нийгмийн дундаж давхаргын хуримтлал, бүтээмжийг нэмэгдүүлэн, хөдөлмөрийн зах зээлийн ил тод байдлыг сайжруулах, нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Уг тогтолцоо нь нь эргээд урт хугацаанд инфляцийг бууруулахад эерэгээр нөлөөлж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангана гэж тооцжээ. Монголбанк орон сууцны тогтвортой тогтолцоог цаашид үргэлжлүүлэх бөгөөд энэ хүрээнд үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээл хөгжиж, Нийгмийн даатгалын сан дахин хөрөнгөжих юм. Түүнчлэн хөдөлмөрийн зах зээл, татвар, шимтгэлийн орчин илүү ил тод тунгалаг болох давуу талтай.

Зах зээлийн дундаж хүүнээс хоёр дахин бага хүүг ипотекийн зээл иргэдэд санал болгосон. Энэ нь зээлийн эрэлтэд “түгжрэл” үүсгэж, орон сууцны борлуулалтад гялалзсан амжилт авчирсан. Зөвхөн иргэд орон сууцтай болоод зогсохгүй үл хөдлөх хөрөнгийн зах зээлд шинэ давалгаа үүсгэсэн. Мөн тухайн иргэн ажилтай, орлоготой байхын зэрэгцээ хуримтлал бүрдүүлэх, худалдан авч буй орон сууцныхаа урьдчилгаа 30 хувийг төлөхийн тулд хэрэглээгээ хэмнэх сэтгэлгээг нийгэмд суулгасан. Өөрөөр хэлбэл, жилийн найман хувийн хүүтэй, 20 жилийн хугацаатай зээл банкны салбарын нийт зээлийн өсөлтөд хурдасгуур болохын сацуу дундаж давхаргаа бэхжүүлэх төрийн бодлоготой яв цав нийцсэн. Тиймээс Засгийн газар орон сууцжуулах хөтөлбөрт Монголбанкт нэг зорилготой байв.

Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох замаар иргэдээ орон сууцжуулах нь Засгийн газар, Монголбанкны бодож олсон “схем”. Хамгийн эрсдэл багатай, сайн нөхцөлтэй, баталгаатай, урт настай орон сууцжуулах хувилбар ипотека байж болох юм. Манай улсад ипотекийн анхдагч зах зээл буюу урт хугацаатай орон сууцны санхүүжилтийн зээл 2003 оноос бий болсон гэж үздэг. Азийн хөгжлийн банкны “Орон сууцжуулах хөтөлбөр”-ийн хүрээнд ипотека Монголд эхлэлээ тавьсан төдийгүй арилжааны банкууд өөрийн санхүүжилтээр уг зээлийг олгох болсноор илүү олон хүн байртай болох нөхцөл бүрдсэн.

Тухайн үед ипотекийн зээл нийт зээлийн 1.3 хувийг эзэлж байсан. Үүнээс хойш орон сууцаа барьцаалаад зээл авсан зээлдэгчийн тоо 50 мянгад хүрч байгаа бөгөөд хоёр их наяд төгрөг энэ зах зээлд байна. Нийт зээлийн хэмжээ таван их наяд төгрөгт хүрсэн тохиолдолд хөтөлбөр бие даан хэрэгжих бүрэн боломжтой хэмээн Төвбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал хэлж байсан удаатай. ДНБ-д эзлэх ипотекийн зээлийн хэмжээ 2003 онд өсөлтийн хувь ▶



- ▶ 0.49 хувь байсан бол 2012 онд 6.04 хувь, өнгөрсөн оны төгсгөлд өмнөх оныхоос хоёр дахин нэмэгджээ.

Ипотекийн зээл гэдэг нь үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан, зээлдэгч нь урьдчилан тодорхойлсон тодорхой хэмжээний төлбөрийг төлөх үүрэг хүлээсэн зээлийг хэлэх аж. Хэрвээ заасан хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд зээлдүүлэгч нь барьцаа хөрөнгө болох орон сууцыг хурааж авах бүрэн эрхтэй. Бусад төрлийн зээлээс ялгаатай нь нэг хүний бус гэр бүлийн зээл байдаг тул харьцангуй эрсдэл багатай гэж үздэг. Тиймээс ипотекийн зээлээс чанаргүй зээл бараг гардаггүйн зэрэгцээ эргэн төлөлт сайтай зээлийн багцад ордог. Иймд банкууд ипотекийн зээлд итгэл үзүүлж, зээлийн багцаа тэлсээр буй.

2014 оноос орон нутагт барьсан, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон амины орон сууцыг хөтөлбөрт хамруулахаар Засгийн газар ипотекийн зээлийн ерөнхий журамд өөрчлөлт оруулж, шинэ зах зээл нээлээ. Түүнчлэн аймаг, сумдад ипотекийн зээлийн хүүг жилийн долоон хувь байхаар тогтоов. Орон нутгийн иргэдийг энэхүү хөтөлбөрт өргөнөөр хамруулснаар тэдний орон сууцны нөхцөл сайжирч, Улаанбаатар хот руу шилжин ирэгсдийн хөдөлгөөнийг сааруулахад томоохон хөшүүрэг болох нь дамжиггүй.

Орон сууцны хөнгөлөлтэй зээл өнгөрсөн оны зургадугаар сарын 17-ноос иргэдэд хүрч эхэлсэн. Урт хугацаатай зээлээр орон сууцтай болох гэсэн иргэдийн дараалал банкны салбарт жилийн турш багагүй ачаалал үүрүүлсэн. Энэ нь орон сууц худалдан авах гэсэн иргэдийн эрэлт өндөр байгааг гэрчилнэ. Монголбанкны зүгээс барилгын материалын дотоодын үйлдвэрлэл, орон сууцны барилгын нийлүүлэлтийг эхэлж дэмжсэнээр өнгөрсөн онд ашиглалтад орсон орон сууцны тоо 2012 оноос 60 хувиар тэлсэн байдаг. Нөгөө талаас орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлсэнээр эрэлт, нийлүүлэлт “уулзлаа”.

Засгийн газар, Монголбанкны хамтран хэрэгжүүлсэн Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд “Барилгын салбарыг дэмжих улмаар орон сууцжуулах дэд хөтөлбөр” ипотек саадгүй хэрэгжих үүдийг нээсэн гэж хэлж болохоор. Ингэснээр барилгын салбарт урьд өмнө нь байгаагүй үсрэлт гарсан. Үүнийг эдийн засагч Ч.Хашчулуун “Барилгын салбарын өсөлтийн цаана төрийн бодлого байсан. Төвбанк, Засгийн газраас барилгын

салбарыг дэмжсэн хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн” хэмээн тайлбарлалаа.

Улаанбаатарт энэ жил 18 мянган айлын орон сууц ашиглалтад орно гэсэн Барилга, хот байгуулалтын яамны судалгаа гарсан. Энэ нь орон сууцжуулах хөтөлбөрт нийлүүлэлтийн хомсдол үүсэхгүй гэсэн үг. Харин эрэлтийг тодорхойлогч иргэдийн худалдан авах чадвар хөтөлбөр урт хугацаанд тасралтгүй хэрэгжих эсэхийг шийдэх гээд байна. Хүний анхдагч хэрэгцээний нэг нь орон сууц. СЭЗДС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн багш доктор Б.Мөнхзаяа “Ипотекийн зээл, үнийн хөөс” өгүүлэлдээ “Ипотекийн зээл авснаар эдийн засагт тогтмол орлоготой, ажилтай иргэдийн тоо өснө. Зээл авсан иргэд нь гэр орноо тохижуулах зорилгоор гэр ахуйн цахилгаан бараа, тавилга зэргийг худалдан авдаг. Энэ нь эргээд жижиг, дунд бизнесийг дэмжих нэг хүчин зүйл болдог” хэмээн бичсэн байдаг.

Ажлын байранд тулгуурласан ипотекийн шинэ тогтолцоо Монголын эдийн засагт үүрээ засаад амжлаа. Нэг жилийн хугацаанд эрчээ алдалгүй эрчимтэй урагшилж, зах зээлд орон зайгаа эзэллээ. Үүнийг гардан хэрэгжүүлэгч нь арилжааны банкууд. Тэдгээрт санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа нь Монголбанк. Тэгвэл урт хугацаанд орон сууцжуулах хөтөлбөрөө авч үлдэхийн тулд зайлшгүй хийх нэг ажил байгаа. Энэ нь үл хөдлөх хөрөнгөөр хоёрдогч зах зээлийг байгуулснаар баталгаажсан үнэт цаас бий болж мөнгөний урсгалаа нэмэгдүүлэх явдал. Үүнийг цогцоор нь хийж чадсан тохиолдолд ипотек зам зуурын бэрхшээлд барьц алдахгүй гэсэн үг.

Монголын ипотекийн корпораци /МИК/ ипотекийн зээлээр баталгаажсан 200 тэрбум төгрөгийн бондыг өнгөрсөн оны төгсгөлд гаргаж амжилттай арилжаалсан. Энэ нь ипотекийн зээлийн зориулалтаар анх удаа бонд гаргасан үйл явдал болсон төдийгүй ирээдүй байгааг давхар харууллаа. Дан ганц банкны эх үүсвэрээр бус хөрөнгө оруулалтын сан, даатгалын сан, тэтгэврийн сан зэргийг орон сууцны зээл рүү татан оруулж байгаа нь хөтөлбөрт итгэх итгэлийг улам нэмэгдүүлж, зах зээлийн сонирхлыг татаж буй. Ингэснээр үнэт цаасны зах зээл идэвхжиж, зээлийн эх үүсвэр түргэн бүрдэж, ипотек урт хугацаанд тогтвортой хэрэгжих гарц нээгдэх юм. ■



Ипотекийн зээлийн хүрээнд сүүлийн хоёр жилийн хугацаанд 20 гаруй мянган хүн найман хувийн хүүтэй орон сууцны зээлд хамрагджээ

Фотог Б.Бямба-Очир

РЕДАКЦИЙН УУЛЗАЛТ

# 90 ЖИЛИЙН ТҮҮХ

## ОЛОЛТ АМЖИЛТ, БЭРХШЭЭЛТЭЙ НҮҮР ТУЛСАН ЦАГ ХУГАЦАА

Тэмдэглэсэн И.ОТГОНЖАРГАЛ, С.БАТЗАЯА

Монгол Улсад банкны салбар үүсч хөгжсөний 90 жилийн ой энэ онд тохиож буй. Тиймээс “Mongolian Economy” сэтгүүл томоохон банкуудын захирлуудыг “Редакцийн уулзалт”-даа урилаа. Бидний

урилгыг Монголын банкны холбооны ерөнхийлөгч М.Болд, “Төрийн банк”-ны гүйцэтгэх захирал Д.Батсайхан, ХААН банкны гүйцэтгэх захирал Норихико Като, “Голомт” банкны гүйцэтгэх захирал

Г.Ганболд, “Худалдаа хөгжлийн банк”-ны гүйцэтгэх захирлын орлогч Д.Хүрэлбаатар нар хүлээн авч, оролцлоо. Банкны салбарын хөгжил, цаашдын ирээдүйн талаар бид хөндөн ярилцсан юм.



М.Болд /Монголын банкны холбооны ерөнхийлөгч/



Г.Ганболд /“Голомт” банкны гүйцэтгэх захирал/



Д.Хүрэлбаатар “Худалдаа хөгжлийн банк”-ны гүйцэтгэх захирлын орлогч



Норихико Като /ХААН банкны гүйцэтгэх захирал/



Д.Батсайхан /“Төрийн банк”-ны гүйцэтгэх захирал/

“ “Банкны төгөл” байгаль орчинд ээлтэй ногоон орчинг бий болгох, түүнийг хамгаалахаас гадна илүү хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх хүсэл эрмэлзлэлийн бэлгэ тэмдэг болсон. ”

“ Орон сууцны зээл хүний амьдралын урт хугацааны хөрөнгө оруулалтыг шийдэж өгч буйгаараа иргэдийг тогтвортой ажлын байртай байлгах, илүү бүтээмжтэй ажиллах хөшүүрэг болж өгч чадсан. ”

“ Бид өөрийн хэмжээнд хөрөнгө татахаас эхлүүлээд бонд босгож, эдийн засагт болон үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулан ажиллаж байна. ”

“ Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа бодлого тодорхойлогчид, зохицуулагч байгууллагууд банкуудыг өрсөлдүүлсэн нь ухаалаг алхам болсон гэж боддог. ”

“ Банкны системийн хөгжил эрх зүйн орчноосоо түрүүлсэн. Цахим төлбөр тооцооны хэрэгслийг банкууд хэрэгжүүлж эхэлсэн ч үүнийг зохицуулсан эрх зүйн зохицуулалт алга. ”

► **-Юуны өмнө Та бүхэнд Монголд банкны салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн баярын мэнд дэвшүүлье. Ойн хүрээнд “Банкны ногоон төгөл”-ийг бий болголоо. Ногоон хөгжлийг банкны салбарынхан хэрхэн харж байгаа талаар яриагаа эхлэх үү?**

**М.Болд:** -Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд өнгөрсөн долоо хоногт / тавдугаар сарын16/ банкны ажилтнууд “Банкны төгөл” нэртэй ногоон байгууламжийг байгууллаа. Энэ нь банкны салбар зөвхөн санхүү, ашгийн төлөө явдаггүй гэдгийг харуулж буй хэрэг. Байгаль орчинд ээлтэй ногоон орчинг бий болгох, түүнийг хамгаалахаас гадна олон нийтэд илүү хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх хүсэл эрмэлзлэлийн бэлгэ тэмдэг болсон гэж бид үзэж байгаа. Өнгөрсөн онд банкууд тогтвортой санхүүжилт нэртэй үүсгэл санаачилгыг эхлүүлээ. Энэ хүрээнд ирэх жилээс банкнаас зээл авч буй харилцагчдад байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй эсэхийг харгалзан үзсэн нөхцөл шаардлага тавина.

**Д.Хүрэлбаатар:** -Юуны түрүүнд үе үеийн банкирууд, банкны системийн нийт хамт олон болон харилцагчиддаа банкны систем үүссэний түүхт 90 жилийн ойн баярын мэнд хүргэе. Ганц Монгол ч биш дэлхий нийтээр байгаль орчинд ээлтэй байх, ногоон хөгжлийг бий болгоход анхаарч эхэллээ. Тиймээс миний хувьд Нийслэлийн иргэдийн тэргүүлэгчдийн хурлын төлөөлөгчийн хувьд хэлэхэд, энэ асуудалд нийслэлийн зүгээс Банкны холбоотой хамтарч ажиллахаар санамж бичиг байгуулахаар ажиллаж байна. Манай холбоо санаачлагчаар оролцох юм.

**Г.Ганболд:** -Банкууд зээлийн шаардлага болон бусад эрсдэлийн бодлогын баримт бичигтээ байгаль орчныг хамгаалах, ээлтэй бизнесийг түлхүү дэмжих чиглэл баримтлах юм. Банкуудад өмнө нь ийм бодлого байсан. Харин одоо үүнийг гүнзгийрүүлж, уул уурхай эрчимтэй хөгжиж буй энэ үед нөхөн сэргээх үйл ажиллагаанд түлхүү дэмжлэг үзүүлэх ёстой юм. Энэ утгаараа ногоон орчинг шинээр бий болгоход анхаарна. Тухайлбал, “Голомт” банк хүлэмжийн аж ахуйг дэмжихээр нэлээд

төсөл хөтөлбөрт санхүүжилт өгөхөөр ярилцаж байна. Ялангуяа дэвшилтэт технологитой өвлийн хүлэмжүүдийг шинээр байгуулах, байгальд ээлтэй шинэ төрлийн хүлэмжийг дэмжиж, санхүүжүүлэх бодлого барьж байгаа. Ногоон хөгжил гэхээр бид нэг тал руу хэт туйлширч болохгүй. Манайд уул уурхай, тэргүүлэх салбар болон хөгжиж байна. Үүн дээр банкуудын хандлага нь зохистой санхүүжилтийг хийх юм. Тэгэхээр Засгийн газрын холбогдох байгууллагуудтай хамтарч шаардлага тавих, уул уурхайн төслийг хэрэгжүүлэхэд анхнаас нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны зардлыг санхүүжилтийн төлөвлөгөөнд нь тусгах нь чухал байна.

**Д.Батсайхан:** -Банк гэхээр хүмүүс мөнгө боддог. Банк мөнгөн урсгалыг зохицуулдаг бизнесийн байгууллага байхаасаа гадна нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж чаддаг байх ёстой. “Сайн яваагаа мэдэрч байгаа бол сайн сайхны төлөө ажил хийж бай” гэсэн үг байдаг. Тэгэхээр хувь хүний болон компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд нийгэмд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулах нь зүйн хэрэг. Энэ утгаараа банкууд хамтран нийгмийн сайн сайхны төлөө олон ажил хийж буйн нэг нь “Банкны ногоон төгөл” юм. Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглахад банкууд хамтарч ажиллаж байна. Үүнээс гадна банк бүрт нийгмийн хариуцлагын хүрээнд хийж байгаа ажлууд бий. Тухайлбал, “Төрийн банк”-ны хувьд байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих “Хүрээлэн” төслийг эхлүүлээд байна. Бид байгаль орчныг хамгаална гэхээр мод тарих мэтээр сэтгээд байдаг. Эцсийн дүнд байгаль орчныг хамгаална гэдэг нь түүнийг танин мэдэх асуудал юм билээ. Энэ талаарх мэдлэгийг боловсролоор дамжуулан олгох үүднээс уг төслийг манай банк эхлүүлээ.

**Норихико Като:** -Энэ жил бид Монголын банкны салбар үүсч, хөгжсөний 90 жилийн ойг тэмдэглэж байна. Өнгөрсөн 90 жилийн хугацаанд тэр дундаа сүүлийн 20 гаруй жилд Монголын банкны салбар хурдацтай өсч, эрс өөрчлөлтийг харуулж чадсан. Би Монголд ирээд гурван жил болж байна. Энэ богинохон хугацаанд банкны салбар шинэ технологиудыг

нэвтрүүлж, дэлхийн жишиг болсон арга техникийг хэрэгжүүлэн, ил тод байдал болон бусад дэвшлүүдийг хөрсөндөө суулгаж эрчимтэй өөрчлөгдөж байгааг биеэрээ мэдэрч байна. Өмнө нь бид дор бүрнээ өөр өөрсдийн ажилдаа анхаардаг байсан бол манай захирлуудын дурьдсанчлан, банкууд ногоон хөгжил, тогтвортой санхүүжилтийн талаар ярилцаж, зарим талаар хамтарч ажиллаж байна. Монголын эдийн засагт хүчтэй санхүүгийн салбар хэрэгтэй. Тиймээс хамтдаа урагшилцгаая.

**-Та бүхэн Монголын банкны салбарын туулсан түүхэн замналыг сайн мэдэх хүмүүс учраас өнгөрсөн хугацааны ололт амжилтаас товчхон хуваалцахгүй юу. Банкны салбар санхүүгийн зах зээлийн 95 хувийг дангаар хангадаг болтлоо хөгжиж чадсаны гол учиг нь юу гэж боддог вэ?**

**М.Болд:** -Монголын банкны салбарт өнөөдрийн байдлаар 10 гаруй мянган хүн ажиллаж байна. Нийт 1.2 сая орчим хадгаламж эзэмшигч, 690 орчим мянган иргэн зээлийн үйлчилгээ авсан. Үүнээс Монголын өрх бүр зээлтэй гэсэн статистик харагдаж буй юм. Бараг хүн бүр банкинд данстай. Улсын хэмжээнд банкны 1500-гаад салбар, нэгж байна. Үүнээс 1000 гаруй нь хөдөө орон нутагт байдаг. Нийт 20 гаруй их наяд төгрөг банкуудад эргэлдэж байна. Энэ нь ДНБ-ий 119 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө юм. Эдгээр үзүүлэлтээр бид манайхтай ижил хөгжилтэй орны түвшинд очсон гэсэн үг. Хөрш зэргэлдээ орнууд болон олон зуун сая хүн амтай, том эдийн засагтай зарим улс ч банкны үйлчилгээг хүн амдаа бүрэн төгс хүргэж чадаагүй байгаа. Бидний дээр дурьдсан тоонд хүрэх гэж мөрөөдөж байна. Тоо талаас нь харвал Монголын банкны салбар маш сайн урагшилсан гэж үзэж болно.

**Д.Хүрэлбаатар:** -Монгол Улсын мөнгө зээлийн түүхийн үе шат дөрвөн хугацаагаар хэмжигддэг юм. Анх 1227 онд Их эзэнт Чингис хааны үед цаасан мөнгө гарсан байдаг. Үүний дараа Их хаадын үед ч төрөл бүрийн зоос, мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргаж байсан түүхтэй. Дараагийн шинэ үе буюу 1922 оны хоёрдугаар сарын 28-нд Улсын түр хурал гэж байхад хоршоо ►

▶ сайжруулах банк гэж байгуулахаар болж улмаар 1924 оны зургадугаар сарын 2-нд 22 ажилтантай Монгол Зөвлөлтийн Худалдаа, аж үйлдвэрийн банк байгуулж байсан түүхтэй. Саяхан Засгийн газрын тогтоолоор энэ өдрийг банкны ажилтнуудын өдөр болгосонд баяртай байгаа. Улмаар 1954 онд ЗХУ-ын Засгийн газраас өөрийн мэдлийн хувьцааг БНМАУ-ын Засгийн газарт шилжүүлсэнээр 100 хувь Монгол Улсын мэдлийн банк болсон юм. Харин 1990 онд банкны дараагийн үе гарч ирсэн. 1991 онд Банкны тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, хоёр шатлалт банкны систем буюу Төвбанк болон арилжааны банкууд бий болж, өнөөг хүртэл хөгжиж ирлээ.

**Д.Батсайхан:** -Түүхэн хөгжил, эдийн засагт оруулж буй хувь нэмрийг нь манай захирлууд ярьсан учраас би бүтээгдэхүүн үйлчилгээний талаар ярья. Сүүлийн 20 гаруй жилд дэлхийн технологид нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг Монголд нэвтрүүлэхээр банкууд түлхүү ажилласан. Сайн ч ажиллалаа. Тиймээс дэлхийн аль ч улсаас төлбөр тооцоо хийж, банкны үйлчилгээ авч чаддаг боллоо. Шинэ бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээ, цахим ертөнцөд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ өргөжин хөгжиж байна. Тэгэхээр технологийн дэвшилд суурилсан банкны тогтолцоо үүссэн энэ үе банкны системд нэлээд жинтэй байр суурь эзлэх байх. Өнгөрсөн жил Азийн банкны холбооны чуулган манай улсад болсон. Үүнийг Монголын банкны холбоо санаачлан зохион байгуулсан. Тэнд ирсэн хүмүүс Монголын банкны тогтолцоо дэлхийн жишигт хүрсэн байна гэж дүгнэсэн. Энэ бол бид зөвхөн дотооддоо биш олон улсад үнэлэгдсэн гэсэн үг. Банкны бүртгэл санхүүгийн асуудал ч банкныхан нэлээд төгөлдөржсөн. Гар аргаас техник технологи рүү шилжлээ. Одоо бүртгэлийн систем олон улсын стандарт руу шилжиж байна. Олон улсад санхүүгийн тайланг уншиж болох хэл рүү шилжиж орсон нь томоохон амжилт юм.

**Г.Ганболд:** -90 жилийн түүх гэдэг ололт амжилт, бэрхшээлтэй нүүр тулсан цаг хугацаа. Банкуудаар дамжиж хэрэгжиж буй төслүүд, түүгээр бий болж байгаа бүтээн байгуулалт, тэнд ажиллаж буй иргэдийг тооцвол

бид олон мянган ажлын байр бий болгож, эдийн засгийг тэтгэхэд оролцож байна. Мөнгө болоод бараа бүтээгдэхүүн үйлчилгээ нийлж баялаг бүтдэг. Тэр утгаараа баялаг бүтээхэд хамгийн идэвхтэй оролцож буй нь банк. Тиймээс баялаг бүтээгч мөн гэж би боддог. Санхүүгийн салбарын 95 хувийг банкны салбар бүрдүүлж байна. Энэ бол бусдаас түрүүлж хөгжсөн ололт. Мөн бид олон улсын түвшинд хүрсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлж байна. Монголын банкны салбар зөвхөн дотоодын арилжааны банкуудаар хэмжигдэхгүй түвшинд хүрчээ. Сүүлийн 20 гаруй жил банкууд өөрөө өөрсдийгөө бүтээсэн. 1998, 2008 оны хямралыг амжилттай даван туулсан. Уул уурхайгүй

“ 2014 оны нэгдүгээр улирлын статистик мэдээллээс харахад банкнаас хамгийн их зээл олгосон нь худалдаа, үйлчилгээний салбар байсан бол дараа нь орон сууцны санхүүжилтын зээл байсан. Өмнө нь байрны зээл нэлээд хойгуур байр эзэлдэг байв. ”

байхад Монголын банкууд ихэнхдээ өөртөөгөө зэрэгцэн явж буй хувийн хэвшлийг хамтдаа авч явсан. Сүүлийн жилүүдэд гаднаас шууд болон шууд бус санхүүжилт орж ирж буй учраас олон улсын оролцоо нэмэгдэж байна.

**Норихико Като:** -Миний бодлоор энэхүү хөгжлийн гол хүчин зүйл нь банкуудын хоорондын өрсөлдөөн болов уу. ХААН банк хувьчлагдах үед Монголын хөдөө аж ахуйн банк нийт 260 салбар нэгжтэй, Улаанбаатар хотод ердөө хоёрхон салбартай байв. Тиймээс ХААН банкны өмнөх удирдлагууд хичээнгүйлэн ажиллаж, орон нутагт болон нийслэлд хүрээгээ тэлж чадсан. Одоо бид орон даяар 530 салбартай болоод байна.

Үүнтэй зэрэгцэн бусад банк ч хүчин чармайлт гаргасан учраас нийслэлийн харилцагч нар хүссэн банкиндаа хандах боломж бүрджээ. Орон нутагт ч мөн адил, нэг суманд гэхэд л 2-3 банкны салбар үйл ажиллагаа явуулж байх жишээтэй. Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа бодлого гаргагчид, зохицуулагч байгууллагууд банкуудыг өрсөлдүүлсэн нь ухаалаг алхам болсон гэж боддог. Үүний үр дүнд банкны зах зээл маш өрсөлдөөнтэй болж, хурдацтай өссөн.

## Сайн ойлголцоод хамтраад эхлүүлбэл болохгүй ажил гэж байдаггүй

**-Банкны салбарын түүхэн хөгжлийн явцад бий болсон олон ололт амжилтын нэг нь моргейж буюу найман хувийн хүүтэй орон сууцны зээл. Олон жил ярьсан зүйлийг жилийн өмнөөс ажил хэрэг болгож чадлаа. Цаашид банкны салбар моргейжийн зээлийг урт хугацаанд авч явах боломж хэр байгаа вэ?**

**Д.Хүрэлбаатар:** -Банкууд нийлж МИК компанийг байгуулж байв. Тэр суурин дээр үндэслэж бонд босгож, эргэж худалдаалах, найман хувьдаа зориулсан хөрөнгө татах боломж бий болж, тэр хэмжээгээр өргөжин ажиллаж байгаа. Засгийн газраас хэрэгжүүлж буй энэ хөтөлбөрт Арилжааны банкууд ч идэвхитэй хамтран ажиллаж байна. Нийслэлээс ч орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхээр ярилцаж байна. Улаанбаатарт хүн амын төвлөрөл өндөр. Нийслэлд газар нь байгаа учраас банкуудтай хамтарч болно шүү дээ. Банк барилгын болон барилгын материалын компаниудыг дэмжих, иргэдийн орон сууцны урт хугацааны хөнгөлөлттэй зээлийг олгох чиглэлээр идэвхитэй ажиллаж байна.

**М.Болд:** -2014 оны нэгдүгээр улирлын статистик мэдээллээс харахад банкнаас хамгийн их зээл олгосон нь худалдаа, үйлчилгээний салбар байсан бол дараа нь орон сууцны санхүүжилтын зээл байсан. Өмнө нь байрны зээл нэлээд хойгуур байр эзэлдэг байв. Сүүлийн хоёр жил орон сууцны ипотекийн зээлийг Засгийн ▶



Фотог Б.Бямба-Очир

Томоохон банкны удирдлагууд банкны салбар цаашид тогтвортой хөгжихөд хууль эрх зүйн зохицуулалт чухал гэж үзэж байна

газар, Монголбанк, арилжааны банкуудтай хамтарч эрчимтэй олгосны үр дүнд амжилттай хэрэгжиж байна. Энэ хугацаанд 20 гаруй мянган хүн жилийн найман хувийн хүүтэй орон сууцны зээлд хамрагдсан байна. Үүнийг өмнөх жилүүдтэй харьцуулахад өдөр шөнө шиг ялгаа харагдана. Цаашид энэ эрчээ алдахгүйгээр явуулахад хамтын хүчин чармайлт чухал байгаа юм.

**Д.Батсайхан:** -Сайн ойлголцоод, хамтраад эхлүүлбэл аливаа асуудалд болохгүй зүйл гэж байдаггүй гэдгийг найман хувийн хүүтэй орон сууцны зээл харууллаа. Өмнөх Засгийн газрын үед жилийн зургаан хувийн хүүтэй “100 мянган айлын орон сууц” хөтөлбөр эхлүүлсэн. Үүний гол ачааг үүрч явсан банк нь манайх. Бид тухайн үед жил гаруйн хугацаанд 1600 гаруй хүнд зээл өгсөн. Тогтолцоо нь буруу байсан учраас тодорхой хайрцагласан хэдэн хүний хүрээнд хомсдолтой эх үүсвэрээр явуулсан нь сөрөг үр дүн авчирсан. Банкууд ч орох сонирхол багатай байв. Энэ мэт туршлаган дээр суурилагдаж найман хувийн хүүтэй зээлийг гаргаж

ирсэн. Ингэхдээ гурван зүйлийг нь өөрчилсөн юм. Хамгийн түрүүнд, хүүг нь нээлттэй, банкуудад орох бололцоотой нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Хоёрт, харилцагчдын хувьд тодорхой хязгаар тавиагүй. Гуравт, барилгын компаниудын оролцоог нээлттэй болгосон. Ингэснээр өмнө нь арилжааны банкуудад байсан маш олон орон сууцны зээл найман хувь руу шилжсэн. Энэ нь нэг харилцагч дээр сард 150-300 мянган төгрөгийн хүүгийн хөнгөлөлт гарч ирж буй юм. Өөрөөр хэлбэл, шууд бус аргаар цалин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээний хөтөлбөр болж чадсан. Энэ зөвхөн ганцхан жишээ. Бид цаашид төр засагтайгаа ойлголцоод аль аль талынхаа эрх ашгийг төвлөрүүлсэн хөтөлбөр боловсруулж чадвал амьдрал дээр хэрэгжих юм. Одооны тогтолцоог би их зөв гэж бодож байгаа. Нөгөөтэйгүүр иргэд тодорхой зорилготой амьдрах хэрэгтэй. Ингэхийн тулд эхлээд хуримтлал бий болгож, дараа нь зээл рүү шилжвэл үр дүнтэй. Энэ хүрээнд “Төрийн банк” өнгөрсөн жил орон сууцны зээл-хадгаламж

гэсэн хосолсон бүтээгдэхүүнийг бий болгосон. Өөрөөр хэлбэл, тухайн иргэн орон сууцны хадгаламж нээлгээд би сар бүр зээлтэй бол хэдэн төгрөг төлөх вэ гэж бодуулаад хийгээд байж болно. Таны төлсөн мөнгө хүүтэйгээ хамт орон сууцны урьдчилгаа төлбөрийн 30 хувийг хангасан өдөр найман хувийн хүүтэй зээл рүү хөрвөх юм.

**Г.Ганболд:** -Орон сууцны зээл санхүүгээс гадна хөрөнгө оруулалтын томоохон хэрэгсэл юм. Хүний амьдралын урт хугацааны хөрөнгө оруулалтыг шийдэж өгч буйгаараа иргэдийг тогтвортой ажлын байртай байлгах, илүү бүтээмжтэй ажиллах хөшүүргийг бий болгож өгч байна. Монголын банкууд 15-16 жил моргейжийн зээл дээр ажилласан туршлагатай. Олон улсын зах зээлд гарах бүрэн бололцоо бий. Орон сууцны зээлд хамрагдах гэхээр 20-30 хувийн урьдчилгаагаа өгч чадахгүй байх тохиолдол түгээмэл. Үүнийг шийдэх олон гарц байгаа байх. Манай банкны хувьд “Мандал” даатгалтай хамтран орон сууцны тодорхой хувийн эрсдэлийг тэд хариуцахаар туршилт ▶

► хийж эхэллээ. Өөрөөр хэлбэл, залуу гэр бүл 10 хувиа гаргаад үлдсэн 20 хувийнх нь эрсдэлийг даатгалын компани хариуцаад явах тухай юм. Манайхан бага хуримтлуулж, их зарцуулаад байх шиг. Хуримтлалыг бий болгох сайн хэрэгслүүд бий болж байна.

**-Орон сууцны зээл хөдөө орон нутагт долоон хувийн хүүтэй байхаар боллоо. Мөн малчид энэ зээлд хамрагдах боломж бүрдсэн. ХААН банк хөдөө орон нутаг тэр дундаа малчдын дунд олон харилцагчтайн хувьд уг зээлийн үйлчилгээг малчдад хэр хүртээмж байлгах вэ?**

**Норихико Като:** -Засгийн газраас хэрэгжүүлж буй орон сууцны хөтөлбөр өнөөгийн зах зээлийн хүүтэй харьцуулахад харьцангуй бага. Энэ нь өмнө нь орон сууц худалдан авах боломжгүй байсан иргэдэд боломж олгосон явдал юм. Иргэд ийм хөтөлбөрийг хүсэн хүлээж байгаа тул энд нийгмийн харилцан зөвшилцөл байна гэж би ойлгож байна. Гэр хороололд, хүнд нөхцөлд амьдарч байгаа олон гэр бүл байгаа. Тиймээс нийгмийн ийм зөвшилцөл байгаа цагт энэ хөтөлбөр үргэлжилнэ. Банкныхан санхүүгийн мэргэжлийн хүмүүс гэдэг утгаараа орон сууцны зээлийн хөтөлбөрийг үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлэхийн төлөө чадах бүхнээ хийж байгаа. Мөн орон нутгийн хувьд энэ хөтөлбөр хэрэгжээд эхэлсэн. Бид зээлийн шийдвэрийг эрүүл, зохистой харьцааны үнэлэмж дээр үндэслэн гаргадаг. Тиймээс зээлийн саналыг нээлттэй хүлээн авч, санхүүжүүлэх боломжтой эсэхийг судална.

## Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд олон талын оролцоо чухал

**-Банкны салбар өнгөрсөн хугацаанд өөрөө өөрсдийгөө бүтээсэн гэж хэллээ. Монголын санхүүгийн үйлчилгээний 95 хувь банкны систем дээр тогтож байна. Бид эдийн засгаа тэлэхийн тулд үүнээс өөр хувилбар сонгох ёстойг мэргэжилтнүүд хэлдэг.**

## Энэ асуудалд та бүхэн ямар байр суурьтай явдаг вэ?

**М.Болд:** Монгол Улсын санхүүгийн салбарын 95 хувийг банкныхан эзэлж байна гэдэг банкуудын сайных гэж хэлж болно. Доголдоод байгаа нөгөө хэсэг нь хөрөнгийн зах зээл. Үүнийг идэвхжүүлэхийн тулд хууль эрх зүйн орчноо сайжруулахын зэрэгцээ шүүхийн тогтолцоо шударга байх хэрэгтэй. Мөн санхүүгийн эх үүсвэр байх ёстой. Энэ гурав нийлж байж хөрөнгийн зах зээл хөгжинө. Банкны салбарын хувьд хийх зүйл маш их байна. Тухайлбал, банкны том зээл олгох чадварыг суулгах шаардлага бий. Улсын хэмжээнд өрнөж буй томоохон бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх чадвар нэг талаараа дутмаг байгаа. Тиймээс банкуудын өөрсдийнх нь хөрөнгө татах чадварыг нэмэгдүүлэх ёстой.

**-Та бүхэн цаашдын салбарын хөгжлөө хэрхэн харж байна вэ. Уул уурхайгаас гадна газар тариалан, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл авахад банкны шаардлага өндөр хэвээр байгааг бизнесмэнүүд хэлдэг. Тухайлбал, “Чингис” бондын хөрөнгөөр санхүүжих төсөл банкны босгын наана үлдэх нь их болсныг ч хэлж байсан.**

**Д.Хүрэлбаатар:** -Банк бүр өөрийн онцлогтой. Нийтлэг шинжтэй үйл ажиллагаа ч явуулж байгаа. Худалдаа хөгжлийн банкны хувьд томоохон харилцагч нарт зориулсан үйлчилгээг түлхүү хэрэгжүүлдэг. Хөрөнгө мөнгө босгоход Монголын улс төр, эдийн засгийн орчноос ихээхэн шалтгаалдаг. Бид өөрийн хэмжээнд хөрөнгө татахаас эхлүүлээд бонд босгож, эдийн засагт болон үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

**Д.Батсайхан:** -Банкны системийн цаашдын хөгжил гэдэг дээр би хэдэн зүйл хэлье. Санхүүгийн секторын 95 хувийг банкны салбар бүрдүүлж байгаагаас харвал манай улсад банкны системийн хөгжил нэлээд өндөр түвшинд очсон байна гэж болох. Гэтэл нөгөө талдаа олон улсын түвшинд авч үзэхэд, Монголын банкууд жижиг хэвээрээ байгаа.

Эдийн засаг өсөхийн хэрээр банкнаас шаардах зүйлүүд өсч буй учраас өргөжих, хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлага бий. Мөн банкны систем цаашид тогтвортой хөгжихөд эрх зүйн зохицуулалт сайн байх нь чухал. Банкны системийн хөгжил эрх зүйн орчноосоо түрүүлээд байгаа. Цахим төлбөр тооцооны хэрэгслийг банкууд аль хэдийнэ хэрэгжүүлж эхэлсэн ч үүнийг зохицуулсан эрх зүйн зохицуулалт алга. Тиймээс эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх шаардлага байгаа. Зээл авахад гарч буй хүндрэлийг манайхан өөрсдөө бий болгоод буй юм. Далд эдийн засаг болон инфляцийн түвшинг бууруулах, бүртгэлийн тогтолцоог шинэчлэх шаардлага байгаа. Гаднын улс орнуудад олон улсын банкууд зээл өгөхдөө хөрөнгө барьцаалахгүйгээр данс барьцаалж өгдөг. Харин манайд үл хөдлөх хөрөнгө гэдэг. Гэтэл гаднынханд данснаас гадуур нэг ч төгрөг эргэлддэггүй байх нь. Бүртгэл нь тодорхой, яг таг учраас үл хөдлөх хөрөнгөнөөс илүү данс барьцаалах нь үр дүнтэй байдаг. Манайд далд эдийн засаг өндөртэй учраас дансаар дамжихгүй байх нь түгээмэл. Албан бус мэдээгээр 40 хувь нь далд эдийн засаг байна гэх тоо бий.

**Г.Ганболд:** -Банкны салбарын ирээдүй цаашид гэрэлтэй байна байх гэж боддог. Улс орны эдийн засаг тэлэхийн хэрээр бизнес дагаад өсөх байх. Бизнес эрхлэгчид банкнаас зээл авахад хэцүү байдаг гэх яриа байдаг. Энэ хоёр талтай ойлголт. Банкны өөрийнх нь борлуулж буй гол бүтээгдэхүүн буюу ашиг олж байгаа гол хэрэгсэл нь зээл. Тиймээс банкууд зээл өгөх сонирхолтой. Гэхдээ нөгөө талдаа иргэдийн, компаниудын эх үүсвэрийг зээл болгож өгч буй учраас бид хариуцлагатай хандах ёстой. Засгийн газрын бондын хувьд ч гэсэн 100 хувь эрсдэлийг нь үүрээд компаниудад өгөөд буцаагаад 2-3 жилийн дараа эргүүлж төлнө. Ийм байхад бид хариуцлагагүй иргэн, компанид зээл өгөх эрхгүй. Тиймээс банкуудын тавьж буй нийтлэг шаардлагыг манай үйлдвэрлэгчид аль аль талдаа биелүүлэх хэрэгтэй. Тэгэхээр зээл авахад хэцүү байгаа нь дан ганц банкнаас хамаараагүй гэдгийг хэлье. Сүүлийн 2-3 жил эдийн засгаа ►

▶ тэлэхийн тулд Төвбанкнаас явуулж буй бодлогыг бид зөв гэж үзэж байгаа.

## Монголчууд өөрсдөө бүтээдэг болсон цагт валютын ханш тогтворжино

**-Банкуудын захирлуудтай уулзсаны валютын ханшийн талаар асуулгүй өнгөрч болохгүй нь. Валютаар зээл авсан аж ахуйн нэгж олон байгаа. Банк төгрөгөөр зээл олгож болдоггүй юм уу?**

**М.Болд:** -Төгрөгийн ханш суларч, ам.долларын ханш чангарч байгааг энгийнээр тайлбарлавал, ам.доллар байхгүй байгаатай холбоотой. Валют гэдэг талхтай адил барааны нэг төрөл. Талх ховордвол үнэ нь өсдөгтэй адил. Монгол Улсад ам.доллар байхгүй учраас төгрөгийн ханш суларч байна. Үүнээс гарах ганц л арга зам бий. Монголчууд өөрсдөө хийж бүтээж сурах ёстой. Ярих бус бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, ядаж л хүнс, гутал хувцсаа өөрсдөө хийгээд өмсчихдөг болох хэрэгтэй. Тэгж байж үнэ ханшийн огцом хэлбэлзлээс гарна. Банкны зээлийн хүүг бууруулахын хувьд хэлэхэд, хувийн хэвшил, төр засгийн хамтын ажиллагаатай холбоотой зүйл. Инфляцийн түвшинг бид хамтын хүчин чармайлтаар буулгах ёстой. Ингэж байж бид хадгаламжийн хүүг бууруулна. Үүний дараа бага хүүтэй зээл олгох боломжтой. Энэ бол ярьсны зоргоор бүтэхгүй. Хамгийн гол нь ярьснаа хийснээр бүтэх юм. Монгол Улсад мөнгөтэй хүн хуруу дарам цөөн. Улсын дотоодын хуримтлал маш бага учраас арилжааны банкууд, төр засаг гаднаас зээлийн эх үүсвэр оруулж ирэх ажлыг гол зорилго болгодог. Энэ зээл валютаар орж ирнэ. Зөвхөн монгол төгрөг хадгаламжаар санхүүжүүлэх зээлийн хэмжээ улсын хэмжээнд маш хязгаарлагдмал байдаг юм. Тиймээс Валютын зохицуулалтын тухай хуулиар зөвхөн банкуудад гадаад валютаар зээл олгох онцгой эрхийг олгосон байдаг. Бусад компани, аж ахуйн нэгж бараа үйлчилгээгээ валютаар үнэлээд эхэлбэл Монгол Улсад үндэсний

мөнгөн тэмдэгт байх шаардлагагүй болно.

**Д.Батсайхан:** -Аливаа бизнес эрсдэлийн менежменттэй байдаг. Аж ахуйн нэгжүүд валютаар эсвэл төгрөгөөр зээл авах нь тэдний өөрийнх нь сонголт. Түүнээс хүн төгрөгөөр зээл авъя гээд байхад нь банкны зүгээс ам.доллараар ав гэж хэзээ ч шаарддаггүй. Авсан зээлээ юунд зарцуулж байна гэдгээс хамаарч тухайн харилцагчид төгрөгөөр үү, валютаар уу гэдгээ шийддэг. Валютын ханш байнга өсдөг зүйл биш. Өсдөг бас буурдаг. Ам.долларын зээлтэй харилцагчдад ханш буурч байвал ашигтай. Ханш унаж байсан үед бизнес эрхлэгчид ашгаа олж байсан түүх бий. Нөгөөтэйгүүр ханш өсөхөөр банк мөнгө олчихдог юм шиг буруу ойлголт нийгэмд байдаг. Ханш өссөнөөс банк ч мөн адил алдагдал хүлээдэг. Учир нь, банкин дээр байршиж буй эх үүсвэр хэн нэгэн хүнийх. Тэгэхээр ханшийн өсөлт нь тухайн хадгаламж эзэмшигчдэдээ очдог юм. Зээлийн хүү өндөр буй нь банкуудын дотоод эх үүсвэрийн зардал өндөр байгаатай шууд холбоотой. АНУ-д зээлийн хүү есөн хувьтай байхад Монголд 18 байна гэж зарим хүн хэлдэг. Үүнд хоёр зүйл шууд хамаардаг. Банк хоёр далавчтай. Нэг нь зээл нөгөө нь хадгаламж. Хадгаламж зээлийнхээ үнэ цэнийг тогтоодог. АНУ-д зээлийн дээд хүү есөн хувь байхад хадгаламжийнх гурван хувь байх жишээтэй. Зээл хадгаламжийн хүүний зөрүү манайд олон улсын жишигт хүрсэн. Гагцхүү хадгаламжийн хүү олон улсын жишгээс 5-6 дахин өндөр, дотоод эх үүсвэрийн өртөг өндөр учир зээлийн хүү буурахгүй байгаа. Цаашид бид хадгаламжийн хүүгээ бууруулах ёстой юм. Ингэж байж хөрөнгийн зах зээл нэмэгдэнэ. Энэ бүх зүйлүүд харилцан бие биедээ хамааралтай учраас нэг субъектын өнцгөөс асуудлыг тайлбарлах нь сайн үр дүн авчрахгүй.

**Норихико Като:** -Ихэнх энгийн иргэдийн орлого нь үндэсний мөнгөн тэмдэгтээр орж, зарлага нь ч бас төгрөгөөр гардаг гэдгийг санах хэрэгтэй. Иргэд гадаад валютаар авч буй зээл ханшийн эрсдэлтэй гэдгийг мэддэг байх ёстой. Зээлийн

хүүгийн хувьд банкуудын хугацаатай хадгаламжийн хүү 15 хувиас дээш буюу инфляцийн түвшингээс өндөр байгаа. Хадгаламжийн хүү инфляциас өндөр буй энэ үед аль болох хуримтлал үүсгэхийг иргэддээ уриалмаар байна. Ингэснээр хүүгийн зардал буурч, эргээд зээлийн хүү буурах нөхцөл бүрдэнэ. Мөн дотооддоо үйлдвэрлэх тусам инфляцийн түвшин буурна. Эдгээрийг хийж чадахгүй бол Монгол төгрөгийн ханшийн сулрал үргэлжилж, гадаадын бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад улам үнэтэй болно. Тиймээс дотоодын үйлдвэрлэл, хуримтлалдаа анхаарцгаа.

**-Гадаадын зарим орны томоохон банк манайд төлөөлөгчийн газраа нээж байна. Цаашлаад салбараа нээх талаар ч дуулдах болж. Энэ нь Монголын эдийн засаг тэр дундаа банкны салбарт ямар үр дүн авчрах вэ?**

**М.Болд:** -Одоогоор гадаадын таван банк Монголд төлөөлөгчийн газраа нээгээд байна. Энэ газрууд болон манайд төлөөлөгчийн газраа нээгээгүй гадаадын банкууд нийлээд хоёр тэрбум ам.долларын зээлийг Монголын хувийн компани, аж ахуйн нэгжүүдэд өгөөд байгаа. Салбар байгуулахгүйгээр төлөөлөгчийн газраараа дамжуулан зээлийнхээ судалгааг хийн банкны үйлчилгээг үзүүлэх боломжтой гэдгийг харуулж байна. Энэ бол зөвхөн эхлэл. Үүнийг цааш үргэлжлүүлэх өргөн боломж бий. Төлөөлөгчийн газруудаас гадна гадаадын банкууд Монгол Улсын арилжааны банкуудын хувьцааг худалдаж авах замаар манай улсад нэмэлт хөрөнгө оруулах бололцоо бий. Мөн Монголын банкуудад зээл олгон хөрөнгийн эх үүсвэр бий болгож, дотоодын арилжааны банкуудаар дамжуулан зээл олгоод олон жил болж байна. Энэ үйл ажиллагааг цаашид улам өргөжүүлэх бололцоотой. Тиймээс байгаа боломжоо бүрэн дүүрэн ашиглах нь Монгол Улсын өнөөгийн эдийн засаг хууль эрх зүйн орчинд илүү тохиромжтой гэж банкууд үзэж байгаа.

**-Цаг заваа гарган ярилцсан та бүхэнд баярлалаа. Цаашдын ажилд тань амжилт хүсье. ■**

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN  
ECONOMY

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

## Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл-14 хоног тутам



СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИД  
ЗАХИАЛГА БАЙНГА АВНА  
УТАС: 7011 5476

ҮНЭГҮЙ  
ХҮРГЭНЭ

# ЧАДВАРЛАГ ХАМТ ОЛОН СҮҮЛИЙН ҮЕИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ЧАНАРТАЙ БҮТЭЭЛ

Сэдэв



- ЭДИЙН ЗАСАГ
- НИЙГЭМ
- УЛС ТӨР
- ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ
- ХҮНИЙ ЭРХ
- ЭРХ ЧӨЛӨӨ
- БАНК
- САНХҮҮ
- УУЛ УУРХАЙ

Шийдэл



- СУРВАЛЖЛАГА
- НЭВТРҮҮЛЭГ
- ЯРИЛЦЛАГА
- ХЭЛЭЛЦҮҮЛЭГ
- РЕКЛАМ
- СУРТАЛЧИЛГАА
- ПРОМО
- ШТОРК


Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, VI хороо  
Их сургуулийн гудамж, АВ CENTER, 503 тоот

УТАС: 70115476  
70115477




ТООН МЭДЭЭ


Арилжааны банкуудын нийт активын ДНБ-д эзлэх хувь



Банкуудын нийт хөрөнгийн хэмжээ, 2013 оны эцсийн байдлаар




Зээлийн төвлөрөл (Бизнесийн салбараар)




Банкны салбарын актив бүтэц



Нийт зээл, зээлийн чанар




Банкны салбарын зээлийн үлдэгдэл, салбараар




Эх сурвалж: Монголбанк


Санхүүгийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүн




Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь



M2-т эзлэх банкнаас гадуурх мөнгөний жин




Мөнгөний нийлүүлэлтийн M2 бүтэц



Нийт хадгаламж, түүний өсөлт, бүтэц



Зээлийн өрийн үлдэгдэл, түүний өсөлт



## ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛ

# ДААТГАГДСАН ИРЭЭДҮЙГ ДАГАХ ЭРСДЭЛ БИЙ ЮУ

Аливаа улс эдийн засагтаа хүнд жин дардаг банк санхүүгийн байгууллагуудынхаа эрүүл мэндийг зөнд нь хаях нь амиа хорлосонтой адил. Учир нь энэ салбар эдийн засгийн “артерийн судас”. Тиймээс дэлхийн улсууд эдийн засгийнхаа аюулгүй байдлыг сахих үүднээс хамгаалалтын дэд бүтцийг бий болгодог. Түүний нэг жишээ нь банкны Хадгаламжийн даатгалын тогтолцоо.

Өнгөрсөн оны нэгдүгээр сард Хадгаламжийн даатгалын хууль батлагдаж, долдугаар сараас төрийн өмчит Хадгаламжийн даатгалын корпораци /ХДК/ үйл ажиллагаагаа эхэлсэн. Тус байгууллага нь иргэдийн арилжааны банкинд байршуулсан хадгаламжийн 20 сая хүртэлх дүнг нь даатгаж буй. Энэ дүн улс бүрт харилцан адилгүй. БНСУ-д дээрх босго 50 сая вон байдаг бол Японд нэг сая иен, АНУ-д 200 мянган ам.доллар байдаг байх жишээтэй. Мэдээж манай улсын хувьд өндөр хөгжилтэй орны хадгаламж даатгах чадамжтай өөрсдийгөө хэрхэн дүйхэв. Энэхүү босго нь иргэн таны итгэлээ өгсөн банкны үйл ажиллагаа эрсдэлд орвол хадгалуулсан мөнгө тань 20 сая төгрөгөөс доош бол гар дээр бүрэн ирэх нь. Дээш байваас хэдийг ч хадгалуулсан хамаагүй 20 саяын босгоор хязгаарлагдана. Манай улсын нийт хадгаламж эзэмшигчдийн 99 хувь нь 20 сая төгрөгөөс доош хадгаламжтай гэсэн судалгаа байдаг. Олон улсын жишгээр нийт банкны харилцагчдын 90 хувийг хамгаалах хэмжээнд байвал хангалттай гэж үздэг байна. Тиймээс бидний хадгаламж хэмээх далд хэтэвч халдашгүй хар хайрцганд байгаа гэж ойлгож болох.

Одоогийн байдлаар хадгаламжийн

даатгалын санд 115 тэрбум төгрөг байна. Анх байгуулагдахад Монголбанк тус санд 50 тэрбумыг, Засгийн газар 35 тэрбумыг төвлөрүүлжээ. Харин өнгөрсөн оны сүүлчээр Хадгаламжийн даатгалын хураамж хэлбэрээр 23 тэрбум төгрөг банкуудаас цуглажээ. Тус корпораци зөвхөн арилжааны банкуудаас хураамж аваад өндөг шиг дараад суух бус өсгөж үржүүлэх үүрэгтэй. Тэд нөөц сангийнхаа мөнгөөр Засгийн газрын бонд худалдан авч хоёр тэрбум төгрөгийн ашиг олжээ. Мөн цаашид ч эрсдэлгүй, зөв хөрөнгө оруулалтын зарчмаар мөнгөө байршуулж, өсгөх зорилго өвөртөлж буй. ХДК-ийн гүйцэтгэх захирал Б.Лхагвасүрэн “Манай сангийн орлого жил бүр хураамжийн орлогоор ойролцоогоор 30 тэрбум төгрөгөөр өснө. Таван жилийн дараа гэхэд жижиг, дунд хэмжээний банкуудын эрсдэлийг даах бядаг болно. Ирэх 10 жилд даатгалын сан тогтоосон хэмжээнд хүрвэл банкуудаас татаж буй хураамжийг зогсооно” хэмээсэн юм. Одоогоор томоохон банкуудын төлж буй хураамжийг харвал, дунджаар жилдээ зургаан тэрбум байхаар байгаа аж. Банкууд өнөөдөр 0.3 хувийн хадгаламжийн даатгалын хураамж төлж буй. Гэвч хадгаламжийн даатгалын асуудалд нэмэлт засвар хийн сайжруулах шаардлага нэлээд буйг банкны төлөөлүүд хэлж байгаа юм. ХХБ-ны Иргэдийн банкны газрын захирал Б.Баярмаа “Манай зүгээс хураамжийг ялгаатай тогтоох ёстой гэж үзэж байгаа. Олон улсын нэр хүндтэй байгууллагаар аудитаа хийлгэн, баталгаажуулдаг мөн зээлжих зэрэглэл, эрсдэлийн үнэлгээгээ тогтоолгосон банкны хувьд олон улсад арай доогуур хураамж төлөх практик бий. Энэ талаар бид

ХДК-ийн удирдлагуудтай саналаа солилцсон. Явцын дунд тэд зарим зохицуулалтуудаа засан сайжруулахад бэлэн байгаа гэж ойлгож байгаа” хэмээсэн юм. Хэдийгээр томоохон дарамт банкууд дээр хураамжаас үүдэн ирэхгүй байгаа ч ялгаатай байдлыг харгалзан үзэж хураамжийн шатлалтай бодлого хэрэгжих ёстой гэх санал хувийн хэвшлийнхэнд байна. Мөн 100 сая төгрөгөөс дээш хадгаламж эзэмшигчийн хүүгийн орлогоос татвар авч, нөгөө талаас ХДК 20 сая төгрөгийг нь даатгаад буй нь хуримтлалтай монгол хүнийг дэмжинэ гэсэн бодлоготой зөрчилдөж буйг хэлэх мэргэжилтнүүд байна.

## Чадах уу?

Хадгаламжийн даатгалын корпораци манай улсын аль нэг банк дампуурахад харилцагчдын хохирлыг 20 саяын босгоороо хэмжин барагдуулаад, араас нь өөрөө үйл ажиллагаагаа тогтвортой явуулж чадах болов уу гэсэн асуулт бидэнд бий.

Банкны салбарын нэг тоглогч нөгөөгөө татан унагаж улмаар улсынхаа эдийн засагт хутга тулгасан тохиолдол цөөнгүй. Энэ байдал сүүлийн жилүүдэд ч олширч буй. Тухайлбал, Исланд улсын банкны салбарын тогтолцоо 2008 онд тэр чигтээ дампуурч, нийт эдийн засгаа элгээр нь мөлхүүлж, Европын улс орнуудын зээл тусламжаар сэхэл авч байсан. Харин манай улсад “Анод”, “Зоос” банк дампуурахад эдийн засаг хасах дүнтэй гарч байсан нь нөлөөллийн цар хүрээг илтгэх биз. “Банкны салбарт асуудал үүссэнийг мэдсээр байж, алдааг засах шийдвэр гаргахгүй яваад байвал сүүлдээ ямар ч сайн хувилбар гарч ирэхээ больдог. Эцэст нь Засгийн ▶

▶ газар тун хатуу арга хэмжээ авахаас өөр аргагүйд хүрдэг” гэж тухайн үед Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч байсан Аршад Саед хэлж байсан байдаг.

“Зоос”, “Анод” банк дампуурахад Төр авралын гараа сунгаж, татвар төлөгчдийн өөрөөр хэлбэл, олон нийтийн мөнгөөр цөөнхийн хохирлыг барагдуулж байсан. Тэгвэл өнөөдөр энэ үүргийг ХДК хүлээнэ. Гэхдээ татвар төлөгчдийн мөнгөнд тэд гар дүрэх эрхгүй. Банкны салбарын эрсдэлийн хашлага Хадгаламжийн даатгалын корпораци байгуулагдаад нэг жилийн хугацаанд үйл ажиллагаагаа явуулж байна. Тус корпорацид учирч болох хамгийн том эрсдэл нь томоохон банк дампуурах.

Олон улсад “Too big to fail” хэмээх зартай ойлголт бий. Энэ нь “дампууруулахад дэндүү томдоно” буюу эдийн засагт өндөр хохирол учруулж болох санхүүгийн байгууллага хавцлын ирмэгт дэнжигнэхэд нүдээ аниад унагачихаж болохгүй гэсэн үг. Үүний нэг жишээ нь 2008 онд Хадгаламж, зээлийн “Washington Mutual” нийгэмлэг нь санхүүгийн нөхцлөөс үүдэн зээлжих зэрэглэлээ хасуулсан бөгөөд улмаар АНУ-ын зургаа дахь том банк болох “Washington Mutual”-аас нь харилцагчид 16.7 тэрбум ам.долларыг ажлын есөн өдөрт татаж, асар богино хугацаанд 22 тэрбум ам.долларын бэлэн мөнгөний гадагшлах урсгал явагдсан байдаг. Иймээс тус банкны үйл ажиллагааг зогсоож, Холбооны нөөцийн Хадгаламжийн даатгалын корпораци

“JP Morgan Chase” компанид 1.9 тэрбум ам.доллараар тус банкныг арилжих арга хэмжээ авч байсан удаатай. Энэ нь АНУ-ын санхүүгийн түүхэн дэх банкны хамгийн том хаалт болон шилжүүлэг болсон байдаг. Тэгвэл түүх давтагдвал яах вэ.

Дээрх үзэгдэл нь нэг талаас Implicit Government Guarantee буюу Засгийн газраас эрсдэлтэй банкуудад санхүүгийн тусламж үзүүлнэ гэсэн “далд” баталгааг санхүүгийн байгууллагуудад өгч байдаг. Өөрөөр хэлбэл, томоохон санхүүгийн байгууллагуудын зүгээс төлбөрийн чадвар алдагдахад Засгийн газраас санхүүгийн тусламж авна гэсэн итгэл үнэмшилтэй болсноор банкны удирдлагууд хадгаламж эзэмшигчдийн хөрөнгөөр хэт эрсдэлтэй үйл ажиллагаа явуулах сонирхлыг өдөөж байдаг. Энэ ойлголтыг “Moral Hazard” буюу ёс зүйн гажуудал гэж тайлбарладаг. Иймд энэ төрлийн далд баталгааг банкуудад төрүүлэхгүй байх, тэдний хадгаламж эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэн хадгаламжийг эрсдэл-өгөөжийн оновчтой түвшинд харгалзах хөрөнгөд байршуулах замаар тогтвортой үйл ажиллагааг дэмжих нь чухал юм.

Энэ асуудлыг шийдвэрлэх хамгийн шалгарсан арга нь Засгийн газраас банкуудын хадгаламжийг бүрэн даатгах бус, харин тэдгээрийн тодорхой дүнд хязгаарлалт хийж даатгах тогтолцоог нэвтрүүлэх асуудал юм. Ингэснээр банкуудын эрсдэлийн удирдлага сайжрах, нөгөө талаас хадгаламж эзэмшигчдийн

зүгээс банкуудад тавих хяналтыг нэмэгдүүлэх, өөрсдийн санхүүгийн системийн талаарх мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд эерэгээр нөлөөлж байдаг.

Монгол улсын хувьд ч дээрх жишгийг дагаж 2008-2012 онд үйлчилж байсан банкуудын хадгаламжийг төрөөс бүрэн батлан даах тогтолцооноос банкуудын хадгаламжийн тодорхой дүнтэй тэнцэх хөрөнгийг даатгах хязгаарлагдмал тогтолцоонд амжилттай шилжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг баталснаар, Хадгаламжийн даатгалын корпорацийн хууль ёсны эрхтэйгээр хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын үйл ажиллагаа явуулах боломж бүрдлээ.

Хадгаламжийн даатгалын корпораци нь бусад даатгалын байгууллагаас үүрэг үйл ажиллагааны хувьд зарчмын ялгаатай тусдаа хуулиар зохицуулагддаг төрөөс үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд бөгөөд банкуудын 20 сая хүртэлх төгрөгийн хадгаламжуудын “хамгаалагч”. ХДК- нь цэвэр хувийн хэвшлийнх гэж байдаггүй бөгөөд зөвхөн хуульд заагдсан этгээдийн хадгаламжийн тодорхой хэсгийг даатгагдгаараа онцлог бөгөөд даатгалын зах зээлийн бусад оролцогчийн өрсөлдөгч гэж үзэх боломжгүй юм. Харин санхүүгийн зах зээлийн зайлшгүй байх оролцогч, эрсдлээс сэргийлэх хэрэгсэл юм. Хадгаламжийн даатгалын тогтолцооны хөгжил, найдвартай байдлыг дүгнэхэд эрт байгаа бөгөөд гагцхүү цаг хугацаа, үйл ажиллагааны үр дүн илтгэх биз ээ. ■

**ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИ**

**ДААТГАГДСАН  
ХАДГАЛАМЖ  
ХАМГААЛАГДСАН  
ХУРИМТЛАЛ**

**ТАНЫ ХАДГАЛАМЖ  
ДААТГАГДЛАА**

Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [www.dicom.mn](http://www.dicom.mn)

ЗУРАГ ТҮҮХ ӨГҮҮЛНЭ



Ю.Цэдэнбал дарга, Ерөнхий хорооны дарга Г.Хүдэрчулуун нар Банкны ахмад ажилтнуудын хамт. 1984 он



Ерөнхий хорооны тэргүүний тоологч Сувдаа.



Улсын ерөнхий хороо 1932-1966 онд энд байрлаж байв



Монголбанкны анх нээхэд 22 хүн ажиллаж байсны дөрөв нь монгол ажилтан байжээ. 1924 он



Монголбанкны барилга



Монголбанкны нэг жилийн ой. Банк байгуулахад оролцож байсан зөвлөлтийн төлөөлөгчдийг Ерөнхий сайд Б.Цэдэндорж хүлээн авч уулзав.



БНМАУ-ын гавьяат эдийн засагч Г.Даянжамц



Монголбанк. 1960 он

Эх сурвалж: Монголбанк

## ОРЧИН ЦАГИЙН БАНКНЫ ТОГТОЛЦОО ҮҮСЧ БЭХЖСЭНИЙ 90 ЖИЛИЙН ОЙД



Д.МОЛОМЖАМЦ

*/Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд асан,  
Эдийн засгийн шинжлэх ухааны доктор/*

# БАНКНЫ СИСТЕМИЙН ХӨГЖЛИЙН ЯВЦ АМАР ХЯЛБАР БАЙГААГҮЙ

### (Дурсамж)

1924 оны дөрөвдүгээр сард Нийслэл хүрээнд Монгол, Зөвлөлт холбоот улсын хамтарсан Монголын худалдаа ба аж үйлдвэрийн банк(Монголбанк)-ийг үүсгэн байгуулах хувь нийлүүлэгчдийн хурал болж, Банкны ерөнхий хороог байгуулан дүрмийг эцэслэн тохирч банк нээх бэлтгэлийг хангах үүргийг Ерөнхий хороонд хариуцуулсан байдаг. Энэ дагуу Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк(Монголбанк)-ны үйл ажиллагаа 1924 оны зургадугаар сарын 2-нд албан ёсоор эхэлсэн түүхтэй.

Миний хувьд Монголын үндэсний банк, зээлийн тогтолцооны хөгжлийн түүхийг таван үе шатад хувааж судалгааны ажил хийж байгаа. Нэгд, Хувьсгалын өмнөх Монгол орны мөнгөн гүйлгээний байдал, хоёрт, Монголын үндэсний банк, зээлийн тогтолцооны үндэс суурь бий болсон 1921-1930 он, гуравт, Банк, зээлийн тогтолцооны хөгжлийн шинэ үе шат болох 1930-1954 он, дөрөвт, Социализмын үеийн банкны тогтолцооны хөгжил 1954-1990, тавд, Банкны хоёр шатлал бүхий тогтолцоо үүсч хөгжсөн үе буюу 1991 оноос

өдий хүртэлх үеийг хамааруулсан. Судалгааны энэ зарчим тухайн үеийн Монголын улс төр, эдийн засгийн байдал, нийгмийн тогтолцоо, төрөөс эдийн засгийг зохицуулах арга хэлбэртэй банкны салбарын хөгжлийг уялдуулан авч үзэх боломж олгодог сайн талтай болно. Автономитын Монголын Засгийн газраас гадаадын банкны салбар нээхийг 1900 онд зөвшөөрч байсан хийгээд 1915 онд Монголын үндэсний банк байгуулах шийдвэр гаргаснаас тооцвол Монгол Улсын орчин цагийн банкны үүсэл, хөгжил 100 гаруй жилийн түүхтэй юм.

Гадаадын мөнгө хүүлэгчдийн эрхшээлд олон зуун жил байж, тэдний үнэн мөн чанарыг танисан Монголын нийгмийн сэтгэл зүйд өөрийн үндэсний банктэй байх, мөнгөн гүйлгээг төрөөс зохицуулах ёстой гэсэн итгэл үнэмшил, үзэл бодол XIX зууны сүүлч XX зууны эхэнд бий болсон байдаг. Түүхийн эх сурвалжаас үзэхэд 1850-иад оны сүүлээс манайд Орос, Хятадаас цагаан мөнгө орж ирэн мөнгөний оронд хэрэглэгдэх болсон байна. Монголын зах зээл дээр тэр үед гурван төрлийн цагаан мөнгө байжээ.

Тухайлбал эхлээд дэнс мөнгө, дараа нь ембүү мөнгө, зоосон цагаан мөнгө таваарын гүйлгээнд мөнгөний үүргийг орон хэрэглэгдэж байж.

Сүм хийдийн Жасын алба нь тухайн үедээ бие даасан томоохон аж ахуй байсан бөгөөд банкны зарим үүргийг давхар гүйцэтгэж байв. Жас сүм хийдийг санхүүжүүлж, хэвийн ажиллагааг хангахаас гадна худалдаа хийж, ардуудад хэрэгцээт барааг нь хүүтэй зээлдүүлж оронд нь Жасын аж ахуйн хэрэгцээний зүйлийг хямд авдаг байжээ.

Их Хүрээнд 1869 онд «Хүү үржүүлэх их сан» байгуулагдаж, мөнгө хүүлэхийн зэрэгцээ банкны үүрэг гүйцэтгэж байж. Уг сангаас 1875 онд 22.9 мянган лан мөнгө зээлээр олгож, түүний хүү 16.9 мянган лан авсан ба 5.436.4 мянган шар цай зээлээр олгож, хүүд нь 3.463.4 мянган шар цай авч байжээ.47 Хүү үржүүлэх сангийн үйл ажиллагаа өргөжиж, цагаан мөнгө ба цайны баталгаа «тийз» гэдэг цаасан тэмдэгт гаргаж зээл олгож мөнгө хүүлэхэд ашиглаж байжээ. Үүнээс үзэхэд XIX зууны эцэст манай оронд таваар мөнгөний харилцаа нэлээд өргөжиж, »

► боловсронгуй болсон байна.

Түүхийн баримтуудаас үзэхэд, ХХ зууны эхэн үе гэхэд Монголын сүм хийдийн жасын үйл ажиллагаа өргөжиж, Хятадын болон гадаадын худалдаачидтай мөнгө хүүлэх талаар өрсөлдөх хэмжээнд хүрч байжээ. Автономитын Засгийн газрын зүгээс гадаадын банкны салбар ажиллуулахыг зөвшөөрч байсны дээр өөрийн үндэсний банк байгуулах боломжийг судалж, зарим оролдлого, алхам хийж байсны жишээ нь 1900 онд Хаант оросын “Орос хятадын банк” нэртэй банк салбараа анх нийслэл Хүрээ болон Улиастай хотод нээн ажиллуулж байжээ.

Монголд салбараа нээсэн гадаадын хоёр дахь банк нь Хятадын Дачин-иньхан банк юм. Тус банк 1907 онд өөрийн салбарыг Их хүрээ болон Улиастайд байгуулсан байна. Эдгээр салбар нь ардууд, ноёд, түшмэдүүдэд зээл олгохын зэрэгцээ хошуудын албаны хэрэгцээнд зориулан мөнгө зээлдүүлж байжээ. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын орон нутгийн салбарууд төсвийн хөрөнгө хүрэлцэхгүйгээс гадны банкны салбараас зээл авч байж. Зээл олгохоос гадна Дачин-иньхан банкны салбарууд манай зах зээл дээр цагаан зоосон мөнгө, цаасан тэмдэгт гүйлгээнд гаргаж, мөнгө хүүлж ашиг олохоор ажиллаж байсан аж.

Автономитын Засгийн газар өөрийн үндэсний банк байгуулахад тусламж авах хүсэлтийг анх Хаант оросын Засгийн газарт тавьж байсан баримт бий. Сайн ноён хан Намнансүрэн тэргүүтэй Засгийн газрын төлөөлөгчид 1913 онд тус улсад айлчилж, нийслэл Петербургт Оросын Засгийн газрын албаныхантай уулзах үедээ Монгол үндэсний банк байгуулах асуудлыг шуурхайлах хүсэлт тавьж байжээ. Мөн манай Засгийн газар 1911 онд тэр үед Засгийн газарт орчуулагчаар ажиллаж байсан Москвитин гэдэг орос хүнд банк нээн ажиллуулах эрх олгосон байна. Москвитин банк байгуулах ажлыг эхэлж чадалгүй удаж, улмаар эрхийн бичгээ Юферов гэдэг хүнд дамжуулан худалдсан байна. Гэвч Юферов уг эрхийн бичгийг Хаант оросын Засгийн газарт өгсөн бөгөөд энэ үндсэн дээр 1.0 сая рублийн дүрмийн сантай банкныг Монголд

байгуулахаар шийдвэрлэж, уг эрхийн бичгийг Сибирийн худалдааны банкинд шилжүүлжээ. Дүрмийн санг бүрдүүлэхийн тулд тус бүр нь 100.0 рублийн үнэтэй 10000 ширхэг акци гаргах, түүний 2000 ширхэг нь Хаант оросын Засгийн газрын, үлдэх 8000 нь Сибирийн худалдааны банкны мэдэлд тус тус байхаар шийдвэрлэж, 1915 оны сүүлээр Их хүрээнд уг банкныг Монголын үндэсний банк нэртэйгээр албан ёсоор нээсэн байна. Монголын үндэсний банк 1915-1917 онд эрчимтэй ажиллаж, монгол, оросын болон тэр үед манайд ажиллаж байсан гадаадын пүүс, компанид зээл олгож байсан байна. Мөн манай иргэд ч үйлчлүүлж байж.

1917 онд Орос оронд октябрын хувьсгал гарч Хаант Засгийн газар огцорч, засгийн эрх большевикуудын гарт шилжсэнтэй уялдаж тус банкны цаашдын хувь заяа тодорхой бус болсон байна. Монголын үндэсний банкны эргэн тойронд үүссэн дээр дурьдсан бэрхшээлтэй, хүндрэлтэй байдлыг харгалзан Сибирийн банкны удирдлагын шийдвэрээр 1919 оны эцсээр тус банкныг хаажээ. Ийнхүү өөрийн үндэсний банктэй болох гэсэн Автономитын засгийн газрын оролдлого бүтэлгүй болж. Гэсэн ч манай Засгийн газар өөрийн гэсэн банк байгуулах, гаднын банкны салбар нээж ажиллуулахыг зөвшөөрөх зэрэг алхмууд хийсэн байна. Тухайлбал, Хятадын «Жунго-инхань» банктэй манай Засгийн газар 1918 оны аравдугаар сард гэрээ байгуулж, тус банкны салбарыг байгуулах зөвшөөрөл олгожээ. Энэ банкны салбараар дамжуулж манай Засгийн газрын төсвийн мөнгөний гүйлгээ хийхийн хамт бусад бүх байгууллагын дансыг тэнд нээлгэх үүргийг Монголын тал хүлээж, түүний оронд засгийн газарт банкнаас зээл олгож байх болсон байна. Мөн Монголын мөнгөн тэмдэгтийг Хятадын банкны салбар гаргах тохиролцоотой байжээ.

Тус банкны салбар үйл ажиллагаагаа эхлээд тун удаагүй байтал Хятадын генерал Сюй-шу-жан тэргүүтэй цэрэг 1919 онд нийслэл хүрээг эзэлж, Монголын автономит эрхийг устгаж Хятадын ноёрхлыг тогтоож эхлэх үед энэ банкны салбарыг хаасан байна. Харин түүний оронд хятад, японы хамтарсан «Жибинь-жань-хань»

банкны салбарыг нийслэл хүрээнд нээн ажиллуулж, «пяоз» нэртэй мөнгөн тэмдэгт хүртэл гүйлгээнд гаргаж, зээл олгож үйл ажиллагаагаа эхэлжээ. Гэтэл октябрын хувьсгалд ялагдсан Оросын цагааны генерал Барон Унгерны толгойлсон цэрэг нийслэл хүрээг эзэлж, Сюй-шу-жаны цэргийг бут цохин Монголын нутгаас хөөн гаргах үед «Жибинь-жань-хань» банкны салбар хаагдсан байна. Ийнхүү гурван жилийн дотор хятадын хоёр банкны салбар түр ажиллаад хаагджээ.

1921 оны Ардын хувьсгал нь Монголын нийгэм, эдийн засгийн байдлыг үндсээр нь өөрчлөхөд хүргэсэн түүхэн үйл явдал болсон. Өөрөөр хэлбэл, манай улсын санхүү-зээлийн тогтолцооны хөгжилд шинэ хуудсыг нээсэн юм. Ардын хувьсгалын үр дүнд МАН-ын байгуулсан Засгийн газрын авч хэрэгжүүлж эхэлсэн эхний арга хэмжээний дотор санхүү, төсөв, гааль, татвар, банк зэрэг олон асуудал чухал байр эзэлж байв. Ардын хувьсгалын дараа өөрийн улсын банк байгуулах, үндэсний валюттай болох зэрэг мөнгөн гүйлгээтэй холбоотой бүх асуудлыг Сангийн яам хариуцаж, мөнгөний зах зээлийг улсын хяналтад авахаас ажлаа эхэлсэн байдаг юм. Мөнгөний эргэлтэд тавих хяналтыг сайжруулах, гадаадын пүүс, компаниас албан татварыг бүрэн хураах зорилгоор 1921 оны долдугаар сард Засгийн газрын тогтоол гарч гүйлгээнд зөвхөн Оросын рубль, Хятадын янчан болон ланг хэрэглэж байхаар шийдвэрлэж. Тэр үед манай зах зээл дээр арилжаалагдаж байсан гадаадын бусад валютын гүйлгээг хориглосон байна.

Гүйлгээнд хэрэглэхийг зөвшөөрсөн гадаадын мөнгөн тэмдэгтүүдийн оросын жижиг цагаан мөнгөтэй харьцах тооцооны жишиг ханшийг түр тогтоож хэрэглэх болсон нь гадны пүүсүүдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгах, татварыг зөв оногдуулах, улсын сан хөрөнгийг арвижуулахад чиглэсэн арга хэмжээ байжээ. Жишээ нь, нэг рубль 250 орос цагаан мөнгөтэй, нэг янчан 350 орос цагаан мөнгөтэй, нэг лан 500 орос цагаан мөнгөтэй дүйцэх солилцооны ханш тогтоосон байна. Эдгээрийг үндэслэн 1921 оноос эхлэн Засгийн газар улсын төсвийг зохиох болж. ►

► Улсын төсвийн тооцоог 1925 он хүртэл лангаар, 1925 оноос мексик доллараар хийж байжээ.

Улмаар 1924 оноос Монгол Оросын хамтарсан худалдаа аж үйлдвэрийн банк(Монголбанк) байгуулагдаж, орчин үеийн банкны тогтолцооны эх суурь тавигдсан билээ. Ийнхүү 1920-иод оны дунд үед шинэ тутам хөгжиж байгаа Монгол Улсын болон арилжааны банкны үүргийг нэгэн зэрэг гүйцэтгэх үүрэгтэй банкны нэг шатлал бүхий тогтолцоо үүссэн байна.

1990 оноос манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжих, өмчийн олон хэлбэрийг үүсгэж хөгжүүлэх алхам хийж эхэлсэн нь Улсын банкны ганц шатлал бүхий тогтолцоог эвдэхэд хүргэсэн юм. Банкны хоёр шатлал бүхий тогтолцоо төлөвшин хөгжих эрх зүйн орчинг бий болгох өргөн хүрээтэй арга хэмжээг 1990-ээд оны дунд үеэс Монголбанкнаас зохион байгуулж хэрэгжүүлсэн. Энэ бүхний үр дүнд манай улсад банкны хоёр шатлал бүхий шинэ тогтолцоо үүсэн бий болж, үйл ажиллагаа нь зүгширч, өнөөдөр банкны салбар Монголын эдийн засгийг урагшлуулан хөгжүүлэх нэг гол зүтгүүр болж чадсан байна. Өнөөдөр манайд 13 банк, 1400 гаруй салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж, банкуудын харилцагчдад үзүүлэх үйлчилгээний тоо өсч, чанар ч сайжирч байна. Банкуудын нийт актив хөрөнгө өнгөрсөн оны сүүлчээр 20.883.706.8 сая төгрөг болсон нь 2008 оноос тав гаруй дахин өссөн байна.

Төрийн мөнгөний бодлогын хүрээнд банкуудын үйл ажиллагаанд Төв банкнаас тавих хяналт сайжирч, банкуудын төлбөрийн чадварын гол үзүүлэлтүүд хэвийн байна. Гэсэн ч манайд банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн анхаарах ёстой олон асуудал бий. Тиймээс эдгээр хүндрэлтэй зарим асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар өөрийн байр суурийг урьдын адил илэрхийлж байх болно. ■

## ОРЧИН ЦАГИЙН БАНКНЫ ТОГТОЛЦОО ҮҮСЧ БЭХЖСЭНИЙ 90 ЖИЛИЙН ОЙД

ЛХАНААСҮРЭНГИЙН ПҮРЭВДОРЖ

*/Монголбанкны ерөнхийлөгч асан, эдийн засгийн шинжлэх ухааны доктор/*



# ХЯМРАЛЫГ ДАВЖ, ӨСӨЛТ ӨӨД МАЦСАН ОН ЖИЛҮҮД

*(Дурсамж)*

Миний бие 2009 оны нэгдүгээр сарын 9-нд Монголбанкны ерөнхийлөгчөөр томилогдож байхад манай улсын эдийн засгийн хямрал хурцдаж байв. Төгрөг өдрөөс өдөрт сулран амьжиргаа, бизнест хүндээр тусч эхэлсэн байлаа. Улс төр, засаглалын аль ч хүрээнд нөхцөл байдлыг гүйцэд үнэлээгүй, даван туулах арга зам тодорхой бус байв.

“Анод” банк ХК дампуурсны дээр, мөнгөний бодлогыг сулруулах шаардлагатай атал Монголбанк чангатгав гэсэн шүүмжлэл их байлаа. УИХ дээр намайг томилогдох үед олонхи гишүүд, ялангуяа Ардчилсан намын бүлгийнхэн мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхийг шаардаж, ам өчиг авахдаа хүрч байсан.

Гэвч нөхцөл байдал эсрэгээрээ дэлхийн эдийн засгийн хямралын нөлөө мэдээж байсан ч улс болгон манайх шиг хүнд байдалд ороогүй. 2006-2008 онд төсөв, мөнгөний бодлогын мөчлөг дагасан тэлэлт явагдсан нь манайд тийнхүү хүндээр тусах үндсэн нөхцөл болсон

байдаг.

32 хувьд хүрсэн өндөр инфляци, төгрөгийн сулрал, хөрөнгийн эх үүсвэрийн дутагдлаар хямралт байдал илрэн гүнзгийрч байв.

Миний хувьд 2008 оны зургадугаар сараас хойш ажилгүй сууж, үйл явдлын хөндлөнгийн ажиглагчийн байр сууринаас хэтрээгүй байв. Уг ажил ч шинэ сэргэг. Эдийн засаг, банкны салбарт үүссэн хямралт байдлыг гүнзгий судалж гарах арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх хүндхэн зорилттой шууд тулгарлаа. Хугацаа өдөр, хоногоор тоологдож эхлэв.

УИХ, Засгийн газрын хэмжээнд ч эрэл судалгаа өрнөж, Олон улсын валютын сангийнхантай хэлэлцээр эхлүүлэн, мөн гаднаас хөрөнгийн эх үүсвэр хайсан ч олдох төлөвгүй байв. Тийм учраас Сангийн сайд С.Баярцогт бид хоёр Олон улсын валютын сантай “Станд бай” хөтөлбөрийн хэлэлцээр хийж, Засгийн газрын хэмжээнд тохирч хэрэгжүүлэх шийдэлд хүрсэн. Тухайн үед үүнээс өөр сонголт байгаагүй юм. Тэгээд ч бид алдаагүй билээ. ►

Ийнхүү 2009 оны гуравдугаар сарын эхээр бидний явах чиглэл тодорч, хэрэгжүүлэх ажилдаа орсон. Төгрөгийн сулралыг зогсоох, валютын нөөцийг цаашид алдахгүй байх нь эхний амин чухал зорилт байв. 1.9 тэрбум ам.долларт хүрч байсан валютын нөөц 700.0 орчим сая ам.долларт хүрч бараг гурав дахин буурсан байлаа. Тиймээс шийдвэртэй хөдлөх хэрэгтэй байсан тул 2009 оны гуравдугаар сарын 19-нд Монголбанкны бодлогын хүүг 4.25 хувиар өсгөн 14 хувиар тогтоов. Мөн сарын 20-нд Монголбанк валютын захад зөвхөн дуудлага худалдаагаар оролцож байхаар шийдвэрлэв.

Аль аль нь эрс шийдэмгий эргэлтийн чанартай арга хэмжээ байлаа. Үр нөлөө нь ч түргэн гарч, хямралын явцыг эргүүлж чадсан түүхтэй. Монголбанк дөрөвдүгээр сарын 6-ны өдрийн хоёрдахь дуудлага худалдаанаас эхлээд захад валют нийлүүлэх бус, харин худалдан авч, валютын нөөцөө нэмэгдүүлж эхэлсэн юм. Өдөр тутам дээш цогин 1575 төгрөгт хүрч байсан албан ханш дөрөвдүгээр сарын эцэс гэхэд 1400 орчим төгрөгт, 1700 давж байсан албан бус ханш албан ханшид ойртон тогтворжсон.

Төгрөгт итгэх итгэл сэргэж, амьжиргаа, бизнесийн бүх хүрээнд гэрэл тусч эхэлсэн бөгөөд төд удалгүй Монголоос хөрөнгө гадагшлах явдал зогсч, харилцах хадгаламж сэргэх хандлагатай болов. Төсвийг эдийн засгийн чадамжинд тохируулан хянаж тогтоосноор макро зохицуулалт уялдан нэг чиглэлд үйлчилж, хямралыг богино хугацаанд гэтлэн давах нөхцөл бүрдсэн учиртай.

Хямралын өрнөлийг зогсоохтой зэрэгцэн Монголбанк бодлогоо эдийн засгийн уналт, агшилтыг сааруулах, цаашдын сэргэлтийг тэтгэхэд чиглүүлэх боломж бий болгосон юм.

Бодлогын хүүгээ 2009 оны тавдугаар сарын эхнээс бараг дөрвөн удаа бууруулан есдүгээр сарын сүүл гэхэд 10 хувьд хүргэв. Энэ арга хэмжээ хямралын явцад эргэлтийн чанартай өөрчлөлт гарсныг нийтэд мэдээлэх, зээлийн тасалдлыг зогсоон, олголтыг нэмэгдүүлэн эдийн засгийн уналт, агшилтыг зогсоож, сэргэлтийг эхлүүлэхэд чиглэгдэж байлаа.

Үр дүн ч гарч 2010 онд мөнгөний нийлүүлэлт 62.5 хувиар, зээлийн үлдэгдэл 23 хувиар өсч, 2009 онд 1.3 хувиар агшсан эдийн засаг 2010 онд 6.1 хувиар өсөх нэг үндсэн хүчин зүйл болсон юм. Бид шуурхай шийдвэртэй ажиллан хямралыг ийнхүү гэтэлж өсөлт өөд шамдаж эхэлсэн байхад дэлхий өнөөдөр ч хямралаас гарч амжаагүй л байна.

2010 онд гадаадын хөрөнгө оруулалт эрс нэмэгдэн нийт эдийн засаг, банкны салбарын түргэн өсөлтийг тэтгэн Монголыг дэлхий харж, хөрөнгө оруулагчдын анхаарлыг өөрийн зүг татаж байлаа. Харамсалтай нь энэ байдал тийм ч удаан үргэлжлээгүй.

Нөхцөл байдал сайжирч эхэлмэгц өчигдрийн хүндрэлийг ор тас мартаад эрх барьж байсан эвсэл манай эдийн засгийн чадамжаас давсан бэлэн мөнгөний амлалтаа биелүүлэхээр зүтгэж, төсөв дахиад л мөчлөг даган тэлж, энэ үйл явдал 2012 оны сонгууль хүртэл улам хүчээ аван сэдэрч, өнөөдөр ч дүрсээ өөрчлөн үргэлжилсээр дараагийн хүнд сорилт, бэрхшээлтэй тулаад байна.

Эдийн засгийн халалтыг саармагжуулах, эрэлтийн болон нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийг хазаарлан барих замаар богино хугацааны өндөр өсөлтийг дунд хугацааны уналт болгочихгүй байхаас өөр бодлогын сонголт Монголбанкинд үлдээгүй юм. 2009 онд 4.9 хувь хүрч буурсан инфляци 2010 оны эхнээс дахин сэргэж эхэлсэн. Мөнгөний бодлогыг сулруулж эхэлсэн нэг жилийн ой тохиож байсан 2010 оны тавдугаар сарын 10-наас 2012 оны гуравдугаар улирал хүртэлх хугацаанд Монголбанк бодлогын хүүгээ дөрвөн удаа нэмэгдүүлсэн байна. Үүний дээр банкны заавал байлгах нөөцийг өсгөх, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх зэрэг мөчлөг сөрсөн зохистой харьцааны арга хэрэгслээр дэмжүүлэн зүтгэсний үр дүнд инфляцийг 10 орчим хувьд барьж чадсан юм. Гэхдээ мөнгөний бодлогоор нийт мөнгөний болон зээлийн өсөлтийг хаачихаагүйгээр барахгүй эдгээр онд дээрх үзүүлэлтүүд өндөр өсөлттэй байж, хувийн салбар, эдийн засгийн өсөлтийн нэг гол эх үүсвэр байсаар ирснийг зориуд тэмдэглэх нь зүйд нийцэх билээ. 2008

онд 2.35 их наяд төгрөг байсан нийт мөнгө 2012 оны хоёрдугаар улиралд 7.1 их наяд төгрөгт хүрч гурав дахин, зээлийн үлдэгдэл 2.1 их наяд төгрөг байсан бол 5.9 их наяд төгрөгт хүрч 2.8 дахин өссөн нь үүнийг гэрчилж байна.

Түүнчлэн үндэснийхээ үйлдвэрүүдийг дэмжих зориулалтаар Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах, зээлийн баталгааны хуулийг батлуулах, орон сууцны санхүүжилтийн анхдагч болон хоёрдогч захыг хөгжүүлэх, Засгийн газартай хамтран зээлийн хүү бууруулах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх зэрэг бодит эдийн засгийг дэмжих олон ажил хийж байлаа. Төсвийн эх үүсвэрийн улирлын дутагдлыг нөхөхөд зориулан зээл олгож байв. Олон удаагийн яриа хэлэлцээрийн дүнд ийм зээлийн хүүг Монголбанкны бодлогын хүүтэй адил байлгах болж, энэ нь зах зээлийн зарчимд шилжсэн.

Мөнгөний бодлого бүхэлдээ төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэж байлаа. 2010 оны турш аажмаар чангарч байсан төгрөгийн ханш 2011 оны дөрөвдүгээр сараас суларсаар он дуусгаж, 2012 онд энэ хандлага хадгалагдсаар байсныг мөнгөний бодлогын шийдэл болгонд тусгаж байлаа.

Монголын эдийн засгийн хамгийн эмзэг асуудал бол төлбөрийн тэнцэл, валютын нөөц байсан, байсаар ч байна. Эдийн засгийн тэлэх, эсвэл уналт бууралтыг хязгаарлах ямар ч бодлогын эн тэргүүний шалгуур нь түүний төлбөрийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл байсаар ирсэн. Үүнийг арай өөрөөр томъёолбол төгрөгийн ханш суурь нөхцлөө даган тогтож, эдийн засаг өөрийгөө тохируулах механизмыг гажуудуулж болохгүйн дээр ханшийн хэлбэлзлийн учир шалтгааныг зөв тодорхойлон бодлого боловсруулахад соргогоор ашиглаж байх нь амин чухал байсан, байсаар ч байх болно.

Төлбөрийн тэнцлийн статистик өгөгдлийн тоо мэдээг чанаржуулах, богино болон дунд хугацааны таамаглал боловсруулж бодлогод ашиглах талаар бид ихээхэн чармайлт гарган багагүй ахиц гаргаж чадсан билээ. ►

► Монголбанк ханшийн бодлогоо дээрх шаардлагад нийцүүлэн долоо хоногт хоёр удаа валютын дуудлага худалдаа явуулан ханшийн огцом хэлбэлзлийг саармагжуулж байлаа. Монголбанкнаас банкуудтай валютын фовард болон төгрөг-долларын, төгрөг-юаны своп хэлэлцээр хийх журмыг анх удаа тогтоон нэвтрүүлсэн нь валютын зах зээлийг өргөтгөх, ханшийн эрсдэлээс хамгаалах чухал арга хэрэгсэл болсоор байна.

Хятадын Ардын банктэй эхлээд 5.0 тэрбум юантай тэнцэх төгрөг-юаны своп хэлэлцээр байгуулж, улмаар 10.0 тэрбум юаны хэмжээнд хүргэн нэмэгдүүлсэн нь хямрал, хүндрэлийн үед төгрөгийн сулралын эрсдэлийг багасгах түүхэн том алхам болсон билээ.

2012 оны Улсын их хурлын сонгуулиар эрх барьж байсан эвслийн амлалтын хугацаа дуусч, Монгол Улс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа жинхэнэ ёсоор хэрэгжүүлж, ингэснээр төсөв зохистой хэмжээгээр тогтворжиж мөнгөний бодлого төсвийн зүй бус тэлэлтийн гаж нөлөөг саармагжуулах жам ёсноос гажсан ачааллаасаа салж өөрийн урсгалдаа орох байх гэсэн итгэл, хүлээлт бидэнд байсан.

2013 онд өмнөх жилүүдэд иргэдэд олгож байсан бэлэн мөнгөний урсгал татарч, тэгснээр эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд мөнгөний бодлогыг сулруулах боломж шаардлага бий болох төлөвтэй байсан.

Нөгөө талаар 2011 оноос эхэлсэн төгрөгийн сулралын дарамт байсаар байсны дээр сонгуулийн өмнөхөн баталсан Гадаадын хөрөнгө оруулалтыг бүртгэх, зөвшөөрөл олгох хуулиар тэртэй тэргүй татарч байсан гадаадын хөрөнгө оруулалтыг улам ч ширгээх эрсдэл дагуулж байгаа нь илт байв.

Монголбанкны ерөнхийлөгчийн ажлаас чөлөөлөгдөх үед Монголбанкны өмнө мөнгөний бодлогоор эдийн засгийн өсөлтийг хадгалан дэмжих, тэгэхдээ төгрөгийн тогтвортой байдлыг хангах, валютын нөөцийн хомсдолд орохгүй байх хоёрдмол зорилт тулгарч ирсэн байлаа. 2012 оны дундаас бодлогын хүүг бууруулах асуудлыг хоёр удаа

авч хэлэлцээд дээрх шаардлагуудыг нарийвчлан судалж эрэмблэх, шинэ Засгийн газрын ааш араншинг ажиглахаар хойшлуулсан. Дэлхийн эдийн засгийн төлөв байдлыг сайтар тандах шаардлага ч бас байсан билээ.

Энэ бяцхан дурсамжийн мөнгөний бодлогын хэсгийг дараах байдлаар төгсгөө гэж бодож байна. 2007 онд эхэлсэн эдийн засгийн хямралаас дэлхий өнөөдөр ч бүрэн гарч чадаагүй байна. Хөгжингүй ертөнцөд анхны нааштай шинж илэрч байгаа хэдий ч хөгжиж буй ертөнцөд байдал зарим талаар муудаж байна.

“ Үндэсний төлбөр тооцооны тогтолцоогоо орчин үеийн технологи-шийдлээр иж бүрэн шинэчлэх судалгааг Өмнөд Солонгос улсын Төлбөр тооцооны төвтэй хамтран хийж, анхны тойм төсөөллийг гарган, улмаар Азийн хөгжлийн банкинд төсөл хэрэгжүүлэх санал тавьж дэмжлэг авсан. Энэ ажил одоо ч үргэлжилсээр байна. ”

Дэлхий ийнхүү найман жил хямралтай хэвээр байхад Монгол Улс эдийн засгаа 2010 он гэхэд тогтворжуулж, улмаар гадаадын хөрөнгө оруулалтыг ихээр татан 2011 онд 17.6 хувийн өсөлтөд хүрч чадсан нь хямралын нөхцөл байдлыг зөв үнэлж макро оновчтой бодлого явуулсны үр өгөөж билээ.

Гэвч эдийн засаг сэргэж эхэлмэгц улс төрийн амлалтын золиосонд дахин өртөж урт хугацаанд тогтвортой хөгжих боломжоо алдаж эхэлсэн. Эдийн засгийн өсөлт өндөр байсан ч маш их халалттай байв. Гадаадын хөрөнгө оруулалтын урсгалын дийлэнхийг бэлэн мөнгөний тараалтаар нөхцөлдсөн хэрэглээний импортын

өсөлт залгиж, туйлшрал, бодлогын алдааны улмаас татарч эхэлсэн юм.

Ийм нөхцөл байдалд Монголбанкны хараат бус бие даасан байдал-мандат чухал үүрэгтэй байсныг зориуд тэмдэглэх нь сургамжтай. Тухайн үеийн төрийн мөнгөний бодлого хямралыг даван туулж, эдийн засгийн өндөр өсөлтийг тэтгэхийн сацуу төсвийн хэт тэлэлтээр нөхцөлдсөн халалтыг саармагжуулан, инфляцийн хөөрөгдлийг хазарлаж, Улсын валютын нөөцийг нэмэгдүүлэн үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хамгаалж чадсаныг бүрэн итгэлтэйгээр дурсах нь надад болон надтай хамт ажиллаж байсан Монголбанкны хамт олонд сайхан байдаг билээ. 2009 онд 1.3 хувиар агшсан эдийн засаг 2010 онд 6.1, 2011 онд 17.3 хувиар өссөн байна. Улсын валютын нөөц 2.9 тэрбум ам.долларт хүрч, төгрөгийн ханш 1300 төгрөг орчимд тогтвортой байсан.

Хямрал банкны салбарт бүр ч хүнд туссан юм. Улсын их хурлаас Хадгаламжийн даатгалын хуулийг батлан гаргаж, Монголбанкнаас банкуудын эх үүсвэрийн хомсдолыг давах чиглэлээр нэлээд ажил хийсэн байв. Өмнө гарсан чиглэлийн дагуу Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийг шаардлага хангасан банкуудад байршуулах, банкны зохистой харьцааны зарим үзүүлэлтийг сулруулах зэрэг шийдвэр гаргаж байлаа.

“Зоос” банк ХК төлбөрийн чадвараа бүрэн алдсан учир татан буугдав. Ийнхүү хэдхэн үгэнд багтааж хэлэхэд хялбар ч тухайн үед амар байгаагүй тал талын дарамт шахалттай байсан нь одоо ч санаанд тод байсаар. Тэгээд ч өөр арга байгаагүй, ингэж шийдвэрлэх нь салбарыг бүхэлд нь эрүүлжүүлэх, санхүүгийн зах зээлийг тогтворжуулах чухал ач холбогдолтой байлаа. Бүх хувилбарыг Засгийн газартай хамтран судалж, Төрийн банк байгуулан, харилцах хадгаламжийг сайн зээлийн хамт шилжүүлэх нь төрөөс гаргах зардлыг багасгах, харилцагчдад чирэгдэл багатай байх шийдэл байсан юм. Манай банкны салбар дээрх хугацаанд Дунд хэмжээний хоёр ч банкаа алдсан нь хэрхэвч мартаж болохгүй, давтаж ►

▸ болохгүй сургамж билээ.

Хямралын сургамж, цаашид банкны салбарыг чадваржуулан бэхжүүлэх, эрсдэлийг бууруулах шаардлагад үндэслэн Төв банк(Монголбанк)-ны тухай хуулинд өөрчлөлт оруулан Банкны тухай хуулийг шинэчлэн найруулж Улсын их хурлаар батлууллаа.

Банкны салбарт үүссэн хямралын үр дагаврыг гүйцэд арилган чадваржуулах нь салбарын төдийгүй эдийн засгийн сэргэлт өсөлтөд нэн чухал байв. Тиймээс банкны төлбөрийн чадварыг дээшлүүлэх шаардлагыг тавьж, шаардлагатай нь төрөөс санхүүгийн эх үүсвэрээр дэмжлэг үзүүлж, 2-3 жилийн дараа буцаан авах, төлж чадахгүй бол банкны хувьцаа болгон хувиргах хөтөлбөрийг боловсруулан Улсын Их хуралд өргөн барьсан боловч дэмжигдээгүй.

Төлбөрийн чадварын болон хямралын бусад хор уршгийг арилгах даалгавар, чиглэлийг банкуудад өгч, хянан хэрэгжүүлэх ажлын хүрээнд гурван банкинд дунд хугацааны хөтөлбөр хэрэгжүүлэн, биелэлтийг улирал тутам дүгнэж банкны эзэд, гүйцэтгэх удирдлагыг нь Төвбанкны зүгээс шахаж ажилласан. Энэ банкуудын хоёр нь хөтөлбөрөө хугацаандаа амжилттай хэрэгжүүлж, харин “Хадгаламж” банк хөтөлбөрийг хэрэгжүүлж чадаагүй учир татан буугдаж, бэлтгэлтэй байсны үр дүнд хохирол донслоого багатайгаар Төрийн банктэй нэгтгэх ажил амжилттай хийгдсэн байна.

Банкны шинэ хуулинд нийцүүлэн хямралаар үүсч бий болсон нөхцөл байдлыг тусган зохистой харьцааны бүх журам, зааврыг шинэчлэн мөрдүүлж, банкны салбарын чадвар сахилгыг бэхжүүлэх, эзэд, хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах болон гүйцэтгэх удирдлагын хариуцлагыг өндөржүүлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлж байлаа.

Монголбанкны хяналт, шалгалтын чадавхийг дээшлүүлж бүтцийг нь өөрчлөн боловсон хүчнээр бэхжүүлж, Дэлхийн банктэй хамтран сургалт, дадлагын хөтөлбөр хэрэгжүүлэн,

банкнд хийх шалгалтын тоог нэмэгдүүлэн давтамжийг ойртуулж, газар дээрх шалгалтын зэрэгцээгээр тайлан тэнцлийн мэдээнд дүн шилжилгээ хийж зөрчил дутагдлыг арилгуулах, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангуулах ажил тасралтгүй хийгдэж байлаа.

Банкны салбарын хэмжээнд ч, банк тус бүр дээр ч зохистой харьцааны мөчлөг сөрсөн бодлого явуулж, дүрмийн сангийн доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэх, өөрийн хөрөнгө, түүний дотор нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хэмжээг өсгөх, заавал байлгах нөөц болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дээшлүүлэх ажил хийсэн юм. Ингэх нь зөвхөн онолын буюу хэтдээ бэлтгэх ажил байгаагүй тулгамдсан шаардлага, зорилт болон хувирах эрсдэл ажиглагдсаар байсныг тэмдэглэх хэрэгтэй. Дэлхийн эдийн засаг хаашаа эргэх нь тодорхойгүй, манай дотоодын нөхцөл байдал ч дунд хугацаанд эрсдэлтэй байх төлөв байсаар байсан учраас Монголбанкны хувьд “хайр нь дотроо ч хал нь гаднаа” байж банкуудад өндөр шаардлага тавьсаар байсан. Тэгээд ч энэ он жилүүдэд банкны салбарын эрс өсөлт, бэхжилтийн үе байлаа. Банкны нийт актив 2008 оны эцэст 3.6 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 55 хувь байснаа 2011 оны эцэст 9.2 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 83.1 хувьд хүрч өсчээ.

Хямралын явцад 163.4 тэрбум төгрөгт хүрч буурсан өөрийн болон түүнтэй адилтгах хөрөнгө 2012 оны гуравдугаар улиралд 1.168.4 тэрбум төгрөгт, зохист харьцаа нь 5.5 хувиас 15.1 хувьд хүрч дээшилсэн байна.

Мөн хугацаанд харилцах хадгаламж 2.3 их наяд төгрөгөөс 6.7 их наяд төгрөг, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 34-60.4 хувь болж өссөн байна. Эдгээр тоо баримт тэр богино хугацаанд банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд хувиар биш харин 3-11 дахин өссөнийг гэрчилж байгаа юм.

Түүнчлэн Хадгаламжийн даатгалын хуулийг дэлхийн туршлага, өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж, Улсын их хуралд өргөн барьж, мөнгө угаах терроризмтай тэмцэх чиглэлийн хууль тогтоомжийг

олон улсын байгууллагын шаардлага, жишигт нийцүүлэн боловсруулах ажлыг хийсэн.

Хямралын үед ч Монгол Улсын төлбөр тооцооны тогтолцоо найдвартай ажиллаж, төлбөр тооцоо хийгдсэн тухайн цаг мөчдөө банк хооронд шилждэг бодит цагийн горимд их болон бага дүнтэй гүйлгээг ээлж дараалан хамруулах, карт эзэмшигчид АТМ төхөөрөмж, ПОС, ПОБ терминалаар аль банкныхаас үл хамааран 24 цагийн турш чөлөөтэй төлбөр тооцоо хийх картын нэгдсэн систем үйлчилгээг нэвтрүүлэх, виза болон Чайна юнион пэй(CUP) олон улсын төлбөрийн картын үйлчилгээтэй нэгдсэн гарцтай болох зэрэг томоохон ажил хийгдсэн.



Үүний зэрэгцээ үндэсний төлбөр тооцооны тогтолцоогоо орчин үеийн технологи-шийдлээр иж бүрэн шинэчлэх судалгааг Өмнөд Солонгос улсын Төлбөр тооцооны төвтэй хамтран хийж, анхны тойм төсөөллийг гарган, улмаар Азийн хөгжлийн банкинд төсөл хэрэгжүүлэх санал тавьж дэмжлэг авсан. Энэ ажил одоо ч үргэлжилсээр байна.

Аливаа Төв банкны бодлого шийдлийн үндсэн зорилго нь санхүүгийн болон бизнесийн хүрээ, олон нийтийг итгүүлэн дагуулахад оршдог. Үүнийг дан ганц мөнгөний бодлогын арга хэрэгслээр хийх боломж бас ч хомс. Хамгийн гол нь олон нийт итгэж дагаж байж л тавьсан зорилго нь сайн хангагддаг. Тиймээс Монголбанк олон нийтэд ил тод байж, бодлого шийдвэрээ хүргэж итгэлийг нь даадаг болохын төлөө их хүч чармайлт гаргаж байлаа. Нөгөө талаар Монголбанк улс төрийн хүрээнд ч, засаглалын хүрээнд ч олон нийтийн дэмжлэг авууштай тохиолдол цөөнгүй гарч байсан. Хямралыг амжилттай даван туулж, өсөлт хөгжил өөд мацан зүтгэсэн тэр он жилүүдэд надтай гар нийлэн ажиллаж байсан Монголбанкны хамт олон үнэхээр чадалтай гэдгийг би дахин дахин хэлэх дуртай. Өнөөдөр ч энэ үгээ давтан хэлж, надад түшиг тулгуур болж байсан та бүхэндээ болон банкны салбарыхандаа 90 жилийн ойн баярын мэнд хүргэж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе! ■

## МӨНГӨ


## 1921-1924 онд гаргасан долларын дэвсгэрт

1921 онд Ардын хувьсгал ялж, шинэ Засгийн газар байгуулан тэр үеийн Сангийн яамнаас ЗСБН-ХОУ-д 3.5 сая долларын мөнгөн тэмдэгт цаасыг захиалан хийлгэжээ. Мөнгөн тэмдэгт цаас нь 50 цент, 1, 3, 5, 10, 25-тын долларын дэвсгэртээр гаргажээ.




## 1925 онд гаргасан гүйлгээний мөнгөн тэмдэгт

1924 онд хуралдсан Улсын Их Хурлаар баталсан анхдугаар үндсэн хуулийн дагуу "Соёмбо" сүлдтэй, монгол үсгээр бичсэн мөнгөн тэмдэгт цаасыг ЗХУ-д үйлдвэрлүүлжээ. Энэхүү мөнгөн тэмдэгт цаасыг 1966 онд гүйлгээнээс албан ёсоор хассан боловч 1940-өөд онд хэрэглээнээс гарсан байжээ. 1, 2, 5, 10, 25, 50, 100 гэсэн дэвсгэрттэй.



## 1939 онд гаргасан гүйлгээний мөнгөн тэмдэгт

Энэ онд гаргасан мөнгөн тэмдэгт цаас нь "Соёмбо" сүлдтэй, нүүрэн талдаа Ардын хувьсгалын удирдагч Д.Сүхбаатарын хөрөг зурагтайгаар ЗХУ-д үйлдвэрлэжээ. Энэхүү мөнгөн тэмдэгт цаасыг 1966 онд гүйлгээнээс албан ёсоор хассан боловч 1955 оноос хэрэглээнээс гарчээ. 1, 3, 5, 10, 25, 50, 100 гэсэн дэвсгэрттэй.



### 1941 онд гаргасан гүйлгээний мөнгөн тэмдэгт

Энэ онд гаргасан мөнгөн тэмдэгтийг 1940 онд баталсан, Үндсэн хуулиар шинэчилсэн “Таван хошуу мал” бүхий сүлдтэй, нүүрэн талдаа Ардын хувьсгалын удирдагч Д.Сүхбаатарын хөрөг зурагтайгаар ЗХУ-д үйлдвэрлэжээ. Энэхүү мөнгөн тэмдэгт цаасыг 1966 онд гүйлгээнээс албан ёсоор хассан. 1, 3, 5, 10, 25, 50, 100 гэсэн дэвсгэрттэй.




### 1955 онд гаргасан гүйлгээний мөнгөн тэмдэгт

Зураач Ши-бу, Д.Амгалан 1940 онд зурснаар баталсан. Улсын албан ёсны бичиг өөрчлөгдсөнтэй холбогдон мөнгөн тэмдэгт цаасан дээрх бүх үсгийг кирилл үсэгт шилжүүлж, “Таван хошуу мал” бүхий сүлдтэй, нүүрэн талдаа Ардын хувьсгалын удирдагч Д.Сүхбаатарын хөрөг зурагтайгаар ЗХУ-д үйлдвэрлэжээ. Энэхүү мөнгөн тэмдэгт цаасыг 1966 онд гүйлгээнээс албан ёсоор хассан. 1, 3, 5, 10, 25, 50, 100 гэсэн дэвсгэрттэй.



### 1966, 1981, 1983 онд гаргасан гүйлгээний мөнгөн тэмдэгт

1966 онд 1, 3, 5, 10, 25, 100 төгрөг, 1981 онд 3, 5, 10, 20, 50, 100 төгрөг, 1983 онд 1, 3 төгрөгийн дэвсгэртүүд тус тус гарчээ. Зураач Ч.Минжүүр, Д.Цэрэнпил нарын зурснаар 1960 онд гарсан Үндсэн хуулиар баталсан шинэ сүлдтэйгээр хийж ЗХУ-д үйлдвэрлэжээ. Энэхүү мөнгөн тэмдэгт цаасыг 1994 онд гүйлгээнээс албан ёсоор хассан.



### 1993 онд гаргасан гүйлгээний мөнгөн тэмдэгт

1992 оны нэгдүгээр сарын 13-нд баталсан Үндсэн хуулийн дагуу БНМАУ гэсэн улсын нэрийг Монгол Улс гэж өөрчилсний дагуу 1993 онд хэвлүүлжээ. Энд Төрийн сүлд зурагдаагүй бөгөөд шинээр монголчуудын төрийн уламжлалт бэлгэдэл “Алтан соёмбо”-ыг хэвлэсэн байна. 1, 5, 10, 20, 50, 100, 500, 1000, 5000, 10000, 20000 гэсэн арван нэгэн дэвсгэрттэй.



## ТЕХНОЛОГИ

# БҮТЭЭГДЭХҮҮН БА ТЕХНОЛОГИЙН “УРАЛДААН”

## Б.ЭНХЦЭЦЭГ

Хоймын авдрандаа мөнгөө хадгалж, хэтэвчиндээ зоосоо тэмтрэн айж, цаасанд боож унаанд дайдаг цаг улираад удаж байна. Тэр ч байтугай банкинд дарааллаа хүлээн эгнэн зогсдог үе ч өнгөрч буй нь банкны үйлчилгээг хүмүүс өөрсдөө удирддаг болохоор хэмжээнд очсоноос харж болох. Сүүлийн жилүүдэд хэрэглэгч өөрөө банкир болж хувирч буй нь банкны салбарын хөгжлийн чиг хандлага. Мэдээж инновацилаг, ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээний тусламжтайгаар.

Анх АНУ-д 1960-аад онд төлбөрийн картыг танилцуулж байжээ. Тэгвэл Монгол Улс 1999-2000 онд буюу 40 жилийн дараа энэ үйлчилгээтэй мэнд мэдэлцэж байж. Түүнээс хойш 1980-аад оны эхээр цахим банкны үйлчилгээг Нью-Йорк анхлан өлгийдэж байсан бол монголчуудад 20 жилийн дараа цахим банкны хэрэглэгчид болох боломж нээгджээ. Олон улсын хөгжлийн чиг хандлага технологи дээр суурилах нь улам эрчимжиж, цахим банкны үйлчилгээ ухаалаг гар утасны аппликейшн үйлчилгээтэй хүч хавсрах болсон нь дэлхийн зах зээл дээр одоогоос дөрөвхөн жилийн өмнө шинэ байсан. Тэгвэл энэ үйлчилгээ хоёрхон жилийн өмнө манай зах зээлд танилцуулагдсан нь бид дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах болсныг гэрчлэх нэг л жишээ. “Голомт” банкны Иргэдийн банкны Маркетингийн хэлтсийн захирал Н.Очирхуяг “Олон улсын банкны салбарын хөгжлийн чиг хандлагаас бид цаг хугацааны хувьд төдийлэн хоцрохоо больсон нь удахгүй монголчууд шинэ бүтээгдэхүүн

үйлчилгээг анхлан гаргаж дэлхийд танилцуулах цаг ойртож буйг гэрчилнэ” хэмээв.

Манай улсын санхүүгийн салбарын 95 хувийг дангаараа бүрдүүлж буй банкны салбарт 13 тоглогч бий. Чөлөөт өрсөлдөөн бүхий олон тоглогчтой ямар ч зах зээл хурдацтай хөгждөг нь жам. Тиймээс ч банкны салбарт шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, инновацийн эрүүл тэмцэл бодитой явагдаж буй. Үүн дундаас хамгийн их цаг мөнгөөрөө ялалт байгуулж буй нь иргэд. Өнөөдөр залуус цахимаар, гар утсаар банкнаас авах бүхий л үйлчилгээгээ өөрөө удирдаж буй бол социализмын үед төрж өсч хүмүүжсэн бидний эмээ өвөө, аав ээж хүртэл банкинд дараалал үүсгэж зогсохын оронд хамгийн их хэрэглэгддэг мөнгөн шилжүүлэг, дансны мэдээлэл харах зэрэг үйлчилгээг мессэжээр хийж, утастайгаа нөхөрлөх болж. Ингээд ирэхээр энэхүү банкны үйлчилгээ авах шинэлэг сонирхолтой шийдлүүдээс иргэд өөрсдөө хоцрох хэмжээнд банкны инноваци хүрчих гээд байх.

## Одоо ба ирээдүй

Өнөөдрийн байдлаар манай банкууд дунд цахим банкны үйлчилгээгүй, ухаалаг утасны аппликейшингүй, мобайл банк үйлчилгээгүй банк гэж үгүй. Цахим банкаар үйлчлүүлэгчдийн тоо банкны салбарт хандагсдын тоотой бараг дүйж буй нь яагаад биеэр очиж банкны үйлчилгээ авах нь багассаныг тод гэрчлэх биз. Тухайлбал, давхардсан тоогоор сард зургаан сая хүн банкны салбаруудаар нь үйлчлүүлдэг Монголын хамгийн олон буюу 1.8 сая харилцагчтай ХААН банкны цахим банкаар хийгдэж буй гүйлгээ өнгөрсөн

оны эцсээр 53 хувьд хүрсэнийг тус банкны Маркетингийн газрын захирал Ц.Оюунцэцэг хэлж байлаа.

Өнгөрсөн намар Монгол Улсад Азийн банкирууд чуулж ололт амжилтаа хэлэлцэж туршлага солилцох үеэр банкны салбарын хөгжил технологид суурилсан шинжтэй байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд дэлхийд хүн төвтэй банкны салбар 30 хувиар хумигдаж, өөртөө үйлчлэх салбарууд олширсныг онцолж байсан. Тэгвэл энэхүү үйлчилгээ ч Монголд аль хэдийнэ байр сууриа олж байгаа. Үүний нэг жишээ нь ХААН банкны 24 цагийн “Экспресс банк” төв юм. Энд олон үйлдлийн систем бүхий АТМ-ууд, интернэт банк ашиглан гүйлгээ хийж, дансны хуулгаа хянах цахим булан, дансны хуулгаа хэвлэх хувилагч машин, ▶



► гадаад шилжүүлэг зэрэг харилцагчдад хэрэгцээтэй бүх үйлчилгээг нэг дор төвлөрүүлжээ. Хамгийн их дараалал үүсдэг хэмээн олны шүүмжлэлийг хүртдэг ХААН банк зарим ачаалалтай салбарууд дээрээ яаралтай бус орлогыг дугтуйгаар хүлээж авах үйлчилгээг ч мөн туршиж байна.

Хүн төвтэй салбараар үйлчлүүлэх хүмүүсийн тоо багасахад нөлөөлсөн том хүчин зүйл нь цахим банк ба гар утасны аппликейшн. Банкуудын ухаалаг утсанд зориулсан аппликейшн нь монголчуудын утсандаа хамгийн их суулгадаг аппликейшнүүд дунд зүй ёсоор багтдаг. Өдгөө банкинд хадгаламжийн данстай иргэд ямарваа нэг гүйлгээ хийхэд банкны дэвтэр хэрэггүй болж бүрэн цахимжсан байдагтай адил төлбөр тооцооны картгүйгээр гүйлгээ хийх боломж мөн бүрдэж, Тухайлбал, Төрийн банк “Цахим төгрөг” хэмээх үйлчилгээг саяхан зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд картгүйгээр аль ч банкны харилцагч илүү шимтгэл төлөлгүйгээр тус банкны АТМ машинаас мөнгө авах, Монголын бүх банк руу шилжүүлэг хийх боломжтой болжээ. Мөн тэдний зүгээс тус банкинд данстай харилцагчиддаа хадгаламжаа барьцаалсан зээлийг интернэтээр цөөн хормын дотор авах болсон нь хугацаа хэмнэсэн шинэлэг үйлчилгээнд тооцогдож, эрэлттэй байна.

Хатуу мөнгө болох картын үйлчилгээ



бидний амьдралын чухал хэсэг. Тэгвэл энэ тал дээр дуулгах сонин олон байна. Тухайлбал, Американ Экспресс картыг хүлээж авч мөнгө олгодог Монголын ганц банк болох “Голомт” нь онцгой эрхтэйгээр анх удаа дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, зээлжих эрхтэй “Американ Экспресс” картыг дотоодын зах зээлд гаргах гэж байна. Мөн тэд өнгөрсөн оны сүүлчээр төгрөгийн данстай олон улсын Мастер карт гаргажээ. Ингэснээр төгрөгийн данстай ч зорьж буй гаднын улсынхаа валютаар картаа ашиглаж болох аж. Өөрөөр хэлбэл, таны дансанд буй мөнгө тухайн улсын мөнгөн тэмдэгттэй шууд харьцах замаар хөрвөнө.

Энэхүү олон улсын картын үйлчилгээнд бүл нэмж буй бас нэг үйлчилгээ бий. Энэ нь SWIFT сүлжээгээр дамжуулан Монгол Улсын гадаад төлбөр тооцооны 50 гаруй хувийг дангаараа гүйцэтгэж, дэлхийн 150 банк, санхүүгийн байгууллагатай хамтын ажиллагаатай “Худалдаа хөгжлийн банк”-ны гурвалсан төрлийн валютын “Юнион Пэй” карт юм. Төгрөг, доллар, юанийн гурван данстай уг карт нь дотооддоо төдийгүй гадаадад ашиглах ба ханшийн хэлбэлзлэлтэй үед тохиолддог эрсдэл төдий чинээ багасна.

Картын бүтээгдэхүүний тал дээр онцлох содон бүтээгдэхүүн ахин нэг байгааг орхигдуулж үл болно. Дэлхий дахинаа “Контактлэсс” буюу зайн технологи банкны үйлчилгээнд нэвтэрч, хэрэглэгчдийн түгээмэл хэрэглээ болоод буй. Тэгвэл үүнтэй зэрэгцэн ХААН банкнаас зайн технологийг нэвтрүүлж, Монголын анхны мэдрэгчтэй “Кисс” картыг гаргажээ. Одоогийн байдлаар мэдрэгчтэй карт уншигч ПОС төхөөрөмжийг 1400 гаруй худалдаа үйлчилгээний газрууд суурилуулаад байна.

Картын үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлж, “Эрэл” банкны зүгээс “Swipe” хэмээх содон үйлчилгээг Монголд хамгийн анх нэвтрүүлсэн. Энэ нь ухаалаг утсандаа банкнаас өгсөн төхөөрөмжийг чихэвчний оролтод залгаж бүх төрлийн төлбөрийн картыг уншуулан өөрийн дансанд төлбөр хүлээн авах боломжтой аж. Дотоодын бүх банкуудын төгрөгийн Мастер, Т-карт, Виза карт унших боломжтой тус жижиг оврын ПОС

төхөөрөмж нь ямар ч гар утас байхаас үл хамааран интернэтэд “WiFi” болон “3G” сүлжээгээр холбогдсон л бол ашиглах боломжтой. Энэ бүтээгдэхүүнийг такси болон бусад хүргэлтийн үйлчилгээнийхэн, замын хөдөлгөөний торгуулийг авах мөн түүнчлэн гүйлгээний дүн өндөртэй хивс тавилга, алт, мөнгөн эдлэлийн худалдаачид хэрэглэх нь ихэсч байгааг тус банкны мэргэжилтэн М.Төгөлдөр хэлсэн юм.

Гаднын улс оронд суугаа найз нөхөддөө мөнгөө шилжүүлэх, эс бөгөөс хүлээн авах иргэдийн хувьд хамгийн олон үйлдэл бүхий удаашралтай үйл явц байсаар ирсэн. Тэгвэл энэ бүхнийг түүх болгох үйлчилгээ зах зээлд ар араасаа цувж байна. Өмнө нь гаднын улсад суугаа нэгэндээ мөнгө шилжүүлэхдээ заавал “Western Union” гэсэн тэмдэглэгээ бүхий банкны салбарууд дээр очдог байсныг “Голомт” банк хялбарчилж, цахим банкаараа дамжуулан аль ч улс руу мөнгөн шилжүүлгийг 24 цагийн турш интернэтээр хийх боломжийг олгох болжээ. Харин энэ тал дээр “Худалдаа хөгжлийн банк” “MoneyGram” хэмээх гадаад хувийн шилжүүлгийн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт хэлбэрийг санал болгож байна. Энэ үйлчилгээ нь дэлхийн 200 гаруй орны 300,000 үйлчилгээний цэгээр үйлчлүүлэхээ ердөө 10 минутанд төлбөрөө ам.доллараар шилжүүлэх мөн ам.доллар, еврогоор тус тус хүлээн авах аж,

Манай банкны салбарт олон бүтээгдэхүүн, үйлчилгээ жилийн жилд, өдрөөс өдөрт нэмэгдэж буй. Үүнд банкны үндсэн үйлчилгээнүүдээс гадна олон шинэлэг тухайлбал ТВ-банк, E-commerce, Хөдөлгөөнт тооцооны төв, Телефон банк, өөрийн сар бүрийн урсгал зардлаа банкны данстайгаа холбуулах, банкаар дамжуулан даатгалаа хийлгэх, шатахууны карт, эмэгтэйчүүдэд, оюутанд зориулсан карт зэрэг гарч тэр ч байтугай цахим хэлбэрээр банкинд бүртгэлтэй хувийн мэдээллээ харилцагч өөрөө шинэчлэх боломж ч бүрдэж, Хэн нэгнээс хамааралгүй өөрийн дансаа удирдаж, банкны үйлчилгээг авч бас бусдад өгч болох боломжийг иргэд хүсэмжлэх болсон өнөө үед банкны салбарын хөгжлийн шинэ чиг хандлагууд ч энэ зүгт жолоогоо залж байна. ■

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

# НОГООН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БАНКУУДЫН НЭГДЭЛ



Монгол Улсад банкны тогтолцоо үүсч хөгжсөнийн 90 жилийн ойд зориулж Монголын банкны холбооныхон Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд "Банкны төгөл" байгуулав. 2014.05.16

## Х.ХУЛАН

Банкууд эдийн засагт зуучлагчийн үүрэг гүйцэтгэдгийн хувьд тогтвортой хөгжилд өвөрмөц бөгөөд чухал үүрэгтэй гэж Нидерландын "Работбанк" группын эдийн засагч Марсель Йокен хэлсэн байдаг. Тэрбээр "Банк тогтвортой бизнес эрхлэх боломжийг санхүүжилтийн бодлого болон төлбөртэй үйл ажиллагааныхаа нөлөөллөөр бий болгодог. Түүнчлэн банкууд зах зээлийн төрөл бүрийн салбар, хууль тогтоомж, зах зээлийн хөгжлийн талаар мэдлэг, мэдээлэл хуримтлуулсан байдаг асар том давуу талтай. Иймд банкууд эдгээр арга хэрэгсэл, мэдлэгээ

ашиглан тогтвортой хөгжлийн түлхэц болж чадна" гэж үзжээ.

Сүүлийн үед байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагаа ухамсарласан тогтвортой санхүүжилтийг дэлхий даяар дэмжих болсон байна. Тийм ч учраас тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах сонирхолтой банк, санхүүгийн байгууллагуудын тоо олон улсын хэмжээнд улам бүр өсч байгаа нь сайшаалтай билээ.

Тэгвэл Монголын санхүүгийн тогтолцооны 95 хувийг дангаараа эзэлдэг манай банкны салбар энэ чиглэлээр юу хийж байгаа бол? ►►

## ▶ Тогтвортой санхүүжилтийн үр Монголын хөрсөнд

“Тогтвортой санхүүжилтийн форум”-ыг өнгөрсөн оны тавдугаар сард Нидерландын хөгжлийн банк, Худалдаа хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, Монголын банкны холбоо, Банк санхүүгийн академи зэрэг байгууллага хамтран зохион байгуулсан. Эл санаачилгыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо дэмжиж, хамтын ажиллагааг өрнүүлсэн юм. Тус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын анхны алхам болсон “Монгол Улсын нийгэм, байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн бодлогыг хөгжүүлэхийн төлөө хамтарсан тунхаг бичиг”-т бүх арилжааны банкны удирдлага 2013 оны арваннэгдүгээр сард гарын үсэг зурсан билээ. Тус тунхагийн дагуу банкууд өөрийн санхүүжүүлэх төсөл бүрийн эдийн засгийн үр өгөөж, эрсдэлийг тооцохын сацуу тэдгээрийн байгаль орчин болон нийгэмд учруулж болох сөрөг нөлөөллийг урьдчилан харж, түүнийг бууруулах, зайлсхийх арга хэмжээ авах юм. Өөрөөр хэлбэл, хүрээлэн байгаа орчинд ээлтэй бизнесийн үйл ажиллагааг банкууд нэгдсэн журмаар дэмждэг шинэ хаалга нээгдсэн гэсэн үг. Харин нөгөө талд байгаль орчинд хор хөнөөлтэй болон бохирдуулах, сүйтгэх үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, химийн гаралтай хорт бодисын санхүүжилтэд банк шууд “Үгүй” гэж хэлэх эрхтэй болжээ. Ингэхдээ байгаль орчныг хамгаалахад өрсөлдөөн байх ёсгүй гэсэн зарчмыг банкууд хүлээн зөвшөөрсний үндсэн дээр дээрх тунхаг бичигт гарын үсэг зурсан байна. Монголын Банкны холбооны ерөнхийлөгч М.Болд “Аливаа бизнес зөвхөн ашгийн төлөө бус, харин байгаль орчинд ээлтэй, хүн ардад хүртээмжтэй, тэдний сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулбал тогтвортой хөгжлийн замнал мөн” гэж тайлбарлав. Түүнчлэн тогтвортой хөгжлийг бий болгохын тулд гэр зуурын арга хэмжээ зохион байгуулах бус, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байж үер дүнд хүрэхийг тэрбээр мөн онцолж байна.

Банкууд ирэх оны нэгдүгээр сар гэхэд зээлийн бодлого, баримт бичигтээ байгаль орчин, нийгмийн хариуцлагын нэгдсэн заалттай болохоор төлөвлөжээ. Энэ тохиолдолд байгаль орчны үнэлгээг хангаж чадаагүй эсхүл тухайн нутгийн ард иргэдтэй зөвшилцөлд хүрээгүй бол зээл хүсэгч нэгээс нөгөө банкинд очсон ч гэсэн зээлийн санхүүжилт авах боломжгүй болно хэмээн банкны эдийн засагч нар тэмдэглэж буй.

Монголын банкууд ийнхүү ногоон хөгжлийн төлөө нэгдэж чадсан бөгөөд тэдний дотор ногоон бодлогод нэлээд хэдэн жилийн өмнөөс анхаарч, шинэлэг санаачилгууд гарган, хэрэгжүүлж буй нь ч цөөнгүй. Тухайлбал, Хасбанк, ХААН банк, ХХБ зэрэг нь энэ чиглэлээр салбартаа “үлгэр дуурайлал” үзүүлж, нийгэмд хүлээн зөвшөөрөгджээ.

## Хас банкны дотоод үйл ажиллагаа байгаль орчинд ээлтэй байхад чиглэдэг

“Эх дэлхий, эрдэнэт хүмүүн, эрүүл ашиг” хэмээх уриатай Хас банк нь “Нийгэм, байгаль орчны тогтолцоо”-г ISO 14001 стандартын дагуу 2002 оноос хэрэгжүүлж байна. Тус банк нь “Дэлхийн тайлагнах санаачилга” буюу Global Reporting Initiative (GRI) болон НҮБ-ын “Global Compact”-д 2007 онд нэгджээ. Ингэснээр байгаль орчин, нийгмийн тулхтай хөгжлийн зарчмуудыг баримтлах үүргийг хүлээж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, түүнийгээ хувь нийлүүлэгчиддээ тогтмол тайлагнадаг аж. Түүнчлэн 2008 онд “Нийгэм, хүрээлэн буй орчны удирдлагын бодлого”-ыг баталсан байна.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зээл олгоход түлхүү анхаардаг тус банк Эко банкны хэлтэстэй. Тэдний зүгээс бичил, жижиг зээл олгохдоо харилцагчийн байгаль орчинд үзүүлэх нөлөө, харилцагчийн ядуурлын бууралтыг хэмжих хүснэгт зэргийг бөглүүлдэг. Ингэснээр үйлчлүүлэгчдэд дээрх үзүүлэлтийн үнэлгээнээс нь хамаарч хүүгийн хөнгөлөлт үзүүлдэг тухай тус банкны Эко банкны хэлтсийн захирал Г.Туул сонирхуулав. Түүнчлэн жижиг, дунд бизнесийн зээлд “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын үнэлгээ” хийхдээ зөрчлийг арилгах зөвлөмж өгч, гүйцэтгэлийг нь хянадаг гэнэ. Тус банк 2009 оноос эхлэн эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүний хэрэглээ болон эко бичил бизнесийг дэмжиж хөнгөлөлттэй зээл олгож эхэлсэн. Мөн ногоон бизнесийг дэмжих үйл ажиллагаагаа улам өргөжүүлж 2013 оноос жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан “Хүлэмжийн хийг бууруулах зээлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Хас банк нь сайн дурын үндсэн дээр банк, санхүүгийн байгууллагуудын үнэлгээ хийдэг, бичил санхүүгээр дагнасан “Planet Rating” агентлагаар өөрийн эрхэм зорилгын хүрээнд тогтвортой хөгжлийн санхүүжилт, байгаль орчин, нийгмийн хариуцлагын чиглэлээр явуулж буй бодлого үйл ажиллагаандаа тогтмол үнэлгээ хийлгэдэг байна.

Банкны ажиллагсад “Хөгжлийн алтан сан” төрийн бус байгууллагыг 2003 онд үүсгэн байгуулсан бөгөөд олон нийтэд чиглэсэн байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг тус сангаар дамжуулан явуулдаг аж. Сонирхуулахад, аймгийн төвүүд болон Улаанбаатар хотод “Хас төгөл” байгуулж 30,000 мод тарьж, тогтмол арчилдаг байна.

Мөн тус банк Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилготой 2010 оноос хойш хэрэгжүүлсэн Мянганы сорилтын сангийн “Цэвэр агаар төсөл”, “Цэвэр агаар сан” болон “Улаанбаатар-цэвэр агаар” төслийн нэгжийн эрчим хүчинд хэмнэлттэй зуух тараах төслүүдийг гүйцэтгэжээ. Түүнчлэн банкны дотоод үйл ажиллагаа байгаль орчинд ээлтэй байхад чиглэдэг аж. Тухайлбал, ажиллагсдын тэтгэврийн нэрийн дансыг Монгол Улсад анх удаа 2007 онд нэвтрүүлсэн, өвлийн улиралд замын түгжрэл болон хорт утааг бууруулах ▶



### Тогтвортой санхүүжилтийн найман зарчим (төсөл)

1. Байгаль орчноо хамгаалах
2. Хүний эрхийг дээдлэх
3. Түүх, соёлын өвөө хамгаалах
4. Ногоон эдийг засгийг дэмжих
5. Санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох
6. Хариуцлагатай, ил тод байх
7. Санхүүжүүлэхийг хориглох нэгдсэн жагсаалт мөрдөх
8. Манлайлан үлгэрлэх

(Эх сурвалж: МБХ)

► үүднээс ажилчдын автобус явуулж, хэвлэмэл зүйлсийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүтээсэн дугуй, давуун торыг худалдан авч ашигладаг гээд эднийд жижиг гэлтгүй ногоон бодлогыг дэмжсэн зүйл их.

### Худалдаа, хөгжлийн банк олон улсын тэргүүн туршлагыг Монголд

Худалдаа, хөгжлийн банк “Байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого”-ыг анх 2012 оны есдүгээр сараас нэвтрүүлсэн. Энэхүү бодлогыг Нидерландын Хөгжлийн банкны санаачилгаар PwC олон улсын аудитын байгууллагатай хамтран амжилттай хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд тус банк нь байгаль орчин, нийгэмд ээлтэй тогтвортой санхүүжилтийг дэмжих бодлогод анхаарал хандуулж томоохон ажлуудыг санаачилжээ. Энэ ажлын хүрээнд байгаль орчин, нийгмийн хариуцлагын бодлого, уг бодлогыг хэрэгжүүлэх заавар, байгаль орчны өндөр эрсдэлтэй салбаруудад ХХБ-аас баримтлах бодлого, олон улсын стандартад нийцсэн харилцагчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэх үнэлгээний арга аргачлалын хамт цогцоор нь боловсруулаад байна.

Нидерландын Хөгжлийн банкны удирдлагууд нь ХХБ-ыг байгаль орчин, нийгмийн хариуцлагын олон улсын тэргүүн туршлагуудыг Монгол улсын банк, санхүүгийн системд анхлан амжилттай хэрэгжүүлэгч банк юм гэдгийг цохон тэмдэглэсэн аж. Харилцагчид байгаль орчин, нийгмийн хариуцлагын чиглэлээр банкны тавьсан нөхцөл, шаардлагыг хүлээн авч, хэрэгжүүлдэг болсон нь уг бодлогын үр дүнг харуулж байна. Мөн байгаль орчин, нийгмийн хариуцлагыг банк, санхүүгийн системээр дамжуулж хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байдаг нь олон улсын туршлагаар нотлогдсон байдаг гэж ХХБ-ны Эрсдэлийн удирдлагын газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Дэлгэрмаа хэлэв.

ХХБ-ны ажиллагсад цаас, эрчим хүчийг хэмнэх санаачлагыг дотооддоо хэрэгжүүлэхээс гадна 2014 онд “Явган аяллын клуб” үүсгэн байгуулж, эх орныхоо үзэсгэлэнт газруудаар явган аялдаг уламжлалтай болжээ.

### Хаан банкны “ногоон” сан

Хаан банк нь 2009 оноос эхэлж зээлийн үйл ажиллагаандаа байгаль орчны тодорхой шалгуур тавьдаг “Байгаль орчны талаар баримтлах бодлого”-ыг баталсан. Үүний дараа 2011 онд байгаль орчин, нийгмийн зарчмуудыг шинэчлэн гаргаж илүү өргөн хүрээнд авч үзэх болсон гэж Хаан банкны Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн Б.Энхбаяр ярих. Эл бодлогыг зээлийн үйл ажиллагаа болон “Хаан банк сан”-гийн үйл ажиллагаанд мөн тусгасан байдаг аж. “Төслийн байгаль орчин, нийгэмд нөлөөлөх эрсдэлийн үнэлгээ”-г 2013 оны нэгдүгээр сараас эхэлж нэвтрүүлсэн аж.

Хаан банк 2007 онд банк санхүү, бизнесийн байгууллагуудаас анхлан дэргэдээ “Хаан банк сан”-г байгуулсан бөгөөд 2013 оныг хүртэл 200 гаруй төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Тус сангийн ногоон үйл ажиллагаанаас нэг жишээ дурдъя. “Хаан банкны ой” хөтөлбөрийг 2008 оноос эхлэн хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгт хүрээлэн, банкны салбар нэгжийн гадна нийт 15 мянга гаруй мод суулгажээ.

Түүнчлэн “Зориг” сангийн “Залуу манлайлал” хэмээх нийгэм, байгаль орчинд ээлтэй төсөл хэрэгжүүлдэг хөтөлбөрийг сүүлийн долоон жил ивээн тэтгэсэн байна.

Ийнхүү 90 жилийн хөгжлийн түүхтэй Монголын банкууд ногоон хөгжил, тогтвортой санхүүжилтийг дэмжиж үйл ажиллагаандаа нэгэн дэвшил авчирч байна. Арилжааны банкууд ногоон хөгжилд идэвх зүтгэлтэй оролцож, гар нийлэн хамтран ажиллаж буй нь тогтвортой санхүүжилтийн хөшүүрэг болох нь дамжиггүй. ■

## ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

## ЭРСДЭЛ

## Б.ТОГТОХ

Санхүүгийн зах зээл мэдрэмтгий. Харилцагчдын итгэл дээр оршин тогтнож байдаг учраас мэдээлэл бүхэн энд үнэ цэнэтэй. Тиймээс тухайн банкны талаарх тоон үзүүлэлт, дотоод засаглал, үйлчилгээ нь хэн нь хэн бэ гэдгийг тодорхойлж өгч байдаг. Өөрөөр хэлбэл, банкны үйл хөдлөл бүхэн олны хараанд өртдөг гэсэн үг. Банктай харилцах хэн ч эерэг болон сөрөг мэдээллийг мэдэрч, түүндээ үндэслэж алхам хийдэг. Энэ салбар өнөөдөр санхүүгийн зах зээлийн 96 хувийг дангаар бүрдүүлж байна. Бүтцээс шалтгаалан банкны салбар том нөлөөтэй байгаа нь энэ.

Банк иргэдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийн сацуу сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлж, түүнээс тодорхой шаардлагатай хэсэгт нь дамжуулан зээлдүүлэх зуучлагч байгууллага. Нөгөө талаас ашиг олох зорилготой Монгол Улсын бизнесийн аж ахуйн нэгжийн нэгэн төлөөлөл.

Манай улсын санхүүгийн тогтвортой байдал арилжааны банкуудын аж байдлаас ихээхэн хамаарч ирсэн. Одоо ч энэ хамаарал хэвээр хадгалагдаж байгаа. Өөрөөр хэлбэл, санхүүгийн тогтвортой байдал арилжааны банкуудын итгэлцэл дээр тогтож буй. Иймээс тэдгээрт анхаарал хандуулж, эрсдэлээс сэргийлэх хяналт, шинжилгээ хийх үүргийг Монголбанкны Хяналт Шалгалтын газар хүлээдэг. Энэхүү хяналт нь зөвхөн Монголд ч биш дэлхий нийтээр банкны үйл ажиллагаанд хяналт тавьж, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй эрсдэлийг хянах, холбогдох бодлогын арга хэмжээ авч ажилладаг түгээмэл ойлголт. Зохицуулалттай хяналт байгаа нь нэг талаар банкны салбарын өнөөдрийн өсөлт хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан нь дамжиггүй.

Эдийн засгийн харилцаанд банк голлох үүрэгтэй оролцож байгаа. Өөрөөр хэлбэл, банк эдийн засгийн “цусны эргэлт”-ийг нь хангаж байдаг газар. Монголын банкуудын нийт актив 2013 онд 20.1 их наяд төгрөгт хүрсэн. Түүний арван хувь нь банкны өөрийн хөрөнгө. Үлдэж буй 90 хувь нь харилцагчдаас татан төвлөрүүлсэн хадгаламж болон эздийн гаднаас татсан эх үүсвэр, зээл. Тиймээс банкны салбарт эргэлдэж буй мөнгө зах зээлийн тогтвортой байдлыг хангаж байдаг учраас зохицуулалт зайлшгүй байх ёстой.

Банк хэмээх лиценз олгосон байгууллагад тухайн харилцагч мөнгөн хөрөнгөө хадгалуулдаг. Үүний цаана итгэлцэл яваа. Найдаж болох баталгаа нь тухайн банкны хариуцлагатай байдал. Тиймээс банкны аж амьдралыг хяналт шалгалт, тооцоо судалгаагүйгээр үнэлэхэд бэрх. Харилцагч гэртээ мөнгөө нуух бус итгэл даах хяналттай байгууллага гэж банкны үйлчилгээг сонгодог. Гэхдээ харилцагчдын мөнгө тодорхой эрсдэл хүлээж, түүнийхээ шанд өгөөж буюу хүү авч байгаа. Харилцагчийн хувьд банкинд тодорхой хэмжээнд хяналт тавих боломжтой. Тухайлбал, санхүүгийн тайлан мэдээтэй тогтмол танилцах байдлаар мэдээлэл авч болно. Үүнд иргэдийн санхүүгийн боловсрол ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх нь мэдээж.

Харин банкны тогтвортой үйл ажиллагааг хэмждэг дэлхий нийтээрээ даган мөрдөх тогтсон стандартууд бий. Энэхүү зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нь банкны бодит байдлыг илэрхийлдэг. Үүнийг ч мөн адил манайх хяналт шалгалтын тогтолцоондоо нэвтрүүлж даган мөрдөөд багагүй хугацааг туулсан. Алдаж оносон түүх бидний ард хоцорлоо.



Төвбанк 2013 онд баталсан хуваарийнхаа дагуу иж бүрэн шалгалтанд үйл ажиллагаа явуулж буй бүх банкыг хамруулжээ. Үүнээс Хадгаламж, Капитрон, Голомт, Зоос болон Анод банкны эрх хүлээн авагчдын зөвлөлийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн нэмэлт шалгалтыг тус тус хийсэн байна. Нэг жилийн хугацаанд 17 удаагийн газар дээрх шалгалт явуулснаас 14 шалгалтын тайланг Монголбанкны захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргажээ. Шалгалтыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэх чиглэлд түлхүү анхаарч, банкны эрсдэлийн үнэлгээний аргачлал нь оновчтой, хүлээж болзошгүй эрсдэлийн талаарх бодлого нь үр дүнтэй эсэх, дотоод хяналтын систем нь хангалттай зэргээр үнэлгээ өгсөн аж.

Таны хадгаламжийн бүрэн бүтэн байдлыг сахин хамгаалах үүрэгтэй банкны өмчлөгч санхүүгийн хариуцлагатай байх учиртай. Энэ бол банк тогтвортой байхад нөлөөлөгч хүчин зүйлийн нэг. Монголбанкны зүгээс банкны өөрийн хөрөнгө, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, зээлдэгчид олгох зээлийн хэмжээ, гадаад валютын гэсэн дөрвөн үндсэн зохистой харьцаа зэргийг тогтоож өгдөг. Эдгээр шаардлагыг тухайн банк ▶

▶ нэн түрүүнд хангаж байх учиртай. Уг зохицуулалтын хэрэгжилтийг Төвбанк хоёрдугаарт хянах ёстой. Гуравт харилцагчдад банк мэдээлэл хүргэж байх үүрэгтэй. Өдөр ирэх тусам тэлсээр буй энэ салбарт эргэлдэх мөнгөн хөрөнгийн хэмжээ цаг үргэлж хяналт, шалгалт шаардах болсон. Энэ нь илүү хариуцлагатай болно гэсэн үг. Ололт амжилтын ард эрсдэл явж байх нь бий.

Төвбанкны тухай хуулийн 19.1 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх, иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, банкуудын зээл, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, шимтгэл, хураамжийн хэмжээг олон нийтэд ил тод, тодорхой болгох хүрээнд цөөнгүй ажил гараанаас хөдөлжээ. Түүнчлэн харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавьж байгаа хэмээн “Монголбанкны 2013 оны тайлан”-д тэмдэглэсэн байна.

Гэхдээ ганцхан хяналт шалгалтаар тухайн байгууллагын үйл ажиллагааг тогтвортой байна гэж дүгнэх нь өрөөсгөл. Тиймээс банкны өмнө ямар эрсдэл “отож” байгааг үнэлэх зайлшгүй шаардлага үүсч байгаа юм. Монголбанкны дэргэд Зээлийн мэдээллийн сан үйл ажиллагаа явуулж ирсэн. Сан нь эрсдэлээс урьдчилан сэргийлэх дэд бүтцийн хүрээнд бий болсон байдаг. Зээлийн мэдээллийн сан нь зээлдэгчийн санхүүгийн хариуцлагын түүхийн лавлах гэж болно. Өөрөөр хэлбэл, банк тухайн зээлдэгчийн талаарх бодит мэдээллийг эндээс авч, зээл өгөх эсэхээ шийднэ гэсэн үг.

Манайд зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага байгаа. Энэ нь зөвхөн Монголбанкны ажил биш. Үүнд Засгийн газрын үүрэг оролцоо ч ихээхэн бий. Цаашдаа зээлдэгчийн санхүүгийн хариуцлагыг өндөржүүлэх, иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах чиглэлээр үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх аж.

Монголбанкнаас хяналт шалгалтын

талаар 2018 он хүртэл баримтлах дунд хугацаанд хэрэгжүүлэх стратегийн баримт бичгийг боловсруулаад байгаа аж. Ингэснээр банкны үйл ажиллагаанд тавих хяналтыг боловсронгуй болгож, эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт, шалгалтын арга, аргачлалыг нэвтрүүлэх боломж бүрдэх юм. Хадгаламжийн даатгалын тогтолцооны тухай хууль өнгөрсөн жил гарсан. Энэ нь харилцагчдад банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх хөшүүрэг болж байна.

Сүүлийн жилүүдэд зээлийн барьцаа хөрөнгөтэй холбоотой эрх зүйн орчны талаар багагүй хөндөх болсон. Тэр тусмаа хөдлөх хөрөнгийн эрх зүйн орчинг бүрдүүлэх нь нэн тэргүүнд хийх ажил болж байна. Энэ хүрээнд чанаргүй зээлийн эргэн төлөлтийг түргэтгэж, банкны зардлыг бууруулах үүднээс үл хөдлөх болон хөдлөх барьцаа хөрөнгөтэй холбоотой найман хуульд нэмэлт өөрчлөлт оруулах аж. Ингэснээр банкны зардал буурч, улмаар зээлийн хүү, шимтгэл, хураамж буурах сайн тал гарах юм.

Төвбанкны зүгээс банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулах зорилтыг Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд сүүлийн жилүүдэд тусган, хэрэгжүүлж ирсэн. Ялангуяа банкуудын эрсдэл даах чадварыг сайжруулах хүрээнд өөрийн хөрөнгийн зохистой харьцааг Базелийн цуврал стандартуудад заасан шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлж байгаа. Энэ нь эдийн засаг эерэг үзүүлэлттэй байгаа нөхцөлд өөрийн хөрөнгөө өсгөж авах явдал.

Монголбанкны Хяналт Шалгалтын газраас банкны системд мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн багц материалыг санхүүгийн тайлагналын стандартад нийцүүлэн шинэчлэх ажлыг эхлүүлжээ. Энэ нь дэлхийтэй бүртгэлийн хувьд нэг хэлтэй болно гэсэн үг. Олон улсын стандартыг мөрдсөнөөр банкны мэдээллийг орчуулагчгүйгээр гадаад түнш шууд хүлээн авах бололцоо бүрдэх юм. Одоогоор туршилтын ажил хийгдэж байгаа бөгөөд энэ онд багтаан нэвтрүүлэх аж.

Хяналт шалгалт хийх аргачлал нь зохицуулалтын хувьд баримт дээр

тулгуурладаг. Гэхдээ асуудал нэгэнт болоод өнгөрсөн хойно арга хэмжээ авах нь бий. Өөрөөр хэлбэл, борооны хойноос цув нөмөрдөг гэсэн үг. Энэ жишгийг арилгах үүднээс эрсдэлд суурилсан хяналт шалгалтаар явбал асуудалд тооцоотой хандаж, бага эрсдэл үүрэх юм. Энэ нь хямрал тохиолдож байсан үеийнхээ тайланд үндэслээд ирээдүйд болох эрсдэлийг үнэлж тооцоолж байх шаардлага банкуудад тулгарч байна. Банкны хоёр шатлалт тогтолцоонд шилжээд 20 гаруй жилийн хугацаанд багагүй тоон мэдээлэл бий болсон. Энэхүү тоон цуваандаа үндэслэж эрсдэлээ тооцоолох боломжтой. Банкны салбар энэ хугацаанд хоёр ч том хямралыг гэтэллээ. Түүнээс багагүй сургамж авсан.

Төвбанкны ерөнхийлөгчийн тушаалаар сүүлийн зургаан сарын турш банкны системийн нийт активын таваас дээш хувийг эзэлж байгаа банкныг “Банкны системийн нөлөө бүхий банк” гэж тодорхойлж хатуу шаардлага дор ажиллахыг үүрэгдэж байгаа. Системд нөлөө бүхий болон бусад банкуудад тавигдах өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуурыг тодорхой хугацааны давтамжтайгаар хангах үүрэг өгч хэрэгжилтэд хяналт тавих болсноор өөрийн хөрөнгийн эрсдэл саарч байгаа юм.

Монголбанкнаас банкуудын хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг шинэчлэн тогтоож, харьцаанд агуулагдах түргэн борлогдох актив ба бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн бүтцийг банкны санхүүгийн байдлыг бодитой харуулахуйц байдлаар өөрчлөн тогтоожээ.

Банкны системийн эрсдэл даах чадварын үзүүлэлт болох өөрийн хөрөнгийн хэмжээ 2013 оны эцэст 1.7 их наяд төгрөгт хүрч, 2012 оныхоос 35.3 хувиар буюу 477.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Банкны салбарын үзүүлэлтүүд харьцангуй сайн байгаа төдийгүй жил ирэх тусам татварын дараах ашгийн хэмжээ нэмэгдэх болсон. Энэ нь салбар эрүүл, зохистой харьцааны үзүүлэлт сайн байгааг илтгэж буй хэрэг. ■



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛААР ТЭРГҮҮЛЭГЧ  
**МОНГОЛ УЛСЫН  
ШИЛДЭГ БАНК**

